

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии



РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

V

Международная конференция
при поддержке Президента Монголии



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Ответственный редактор: Академик С.Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И.В.Кульганек
доктор (Ph.D) Н.Хишигт
кандидат филол. наук Д.А.Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г.Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор:
Эмхтгэгч-редактор:

Академич С.Чулуун
Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан "Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга" 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology



RUSSIAN ACADEMY OF
SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

V

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar
2023

HHА 63.4
ДАА 930.1
М-694

Edited and compiled by

acad. S.Chuluun
D.Sc.(Philology) I.V.Kulganek,
Ph.D (History) N.Khishigt,
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

Cultural heritage of the Mongolis: manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И.Ф.Поповой	11
Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ	13
Приветствие генерального секретаря международной ассоциации монголоведов, академика С.Чулууна	15
Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн мэндчилгээ	
Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын мэндчилгээ	

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх.

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

Э. Баярчимэг

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх
дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

К. И. Бикмаева

Национальные программы по монгольской письменности
(монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных
документов в области языковой политики монголии

Л. Ганбат

Ибн Арабшах-ийн “Asāibu’l makdûr” зохиолд нүүдэлчдийн
байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

Л. С. Дампилова

Жанровое разнообразие архивных материалов Монгольской
экспедиции 1967 года

И. М. Захарова, М. В. Мандрик

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

И. В. Кульганек, Н. В. Захарова

Фотографии о монголии и монголах в Институте восточных
рукописей РАН

Э. Мөнхцэцэг

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж
толь бичгийн тухай

Б. Нацагдорж, О.Оюунжаргал

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

Д. А. Носов

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

Р. Ю. Почекаев

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

Э. Пүрэвжав

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

Т. Д. Скрынникова

Сакральность правителя и его ритуальные функции
(По материалам анонимной Altan tobči)

М. В. Федорова

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из
экспедиции в Северную Монголию (1910 г.)

А. Д. Цендина

Гадания на кубиках (по материалам квартиры-музея
Ц.Дамдинсүрэна и коллекции Р.Отгонбаатара)

Б.-Х. Б. Цыбикова

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

С. Чулуун, Н.Хатанбаатар

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в
Монгольском гоби

Т. И. Юсупова

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Дорно Дахины Гар бичмэлийн хүрээлэнгийн 2013 оноос эхлэн хамтран зохион байгуулж буй “Монголчуудын соёлын өв: архивын баримт, гар бичмэлийн цуглуулга” олон улсын эрдэм шинжилгээний хурал нь 2021 онд 5 дахь удаагаа зохион байгуулагдсан билээ. Анхны хурлыг Санкт-Петербург хотноо Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан бөгөөд 2013 онд Улаанбаатар хотод, 2015 онд Санкт-Петербург хотод, 2017 онд Улаанбаатар хотод, 2019 онд Санкт-Петербург, 2021 онд Санкт-Петербург хотод (цахимаар) болсон юм. Эдгээр хуралд олон орны эрдэмтэн судлаачид оролцож Монголын түүх, гар бичмэл, архивын баримт, хэл шинжлэл, утга зохиол, археологи зэрэг монгол судлалын тулгуур асуудлаар олон арван сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлж, нийт энэ удаагийн цуврал нь V дахь өгүүлэлийн эмхэтгэл болон нийтлэгдэж байна.

Хэдийгээр цар тахлын хүнд үе байсан ч бид уг хурлыг таслалгүй 2021 оны 4 сард зохион байгуулж олон эрдэмтэн судлаачид сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлсэн юм. Энэ удаагийн хурлаар Монгол Улсын Үндэсний Төв архивын Түүхийн баримтын архив, Үндэсний Номын сан, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төв, Хэл зохиолын хүрээлэнгийн гар бичмэлийн сан, академич Ц.Дамдинсүрэнгийн гэр-музей, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний архив, Оросын ШУА-ийн архив, Санкт-Петербургийн Улсын Номын сан, Оросын угсаатны музей, ОХУ-ын Кино гэрэл зургийн архив болон БНТУ, Япон улсад хадгалагдаж буй монголчуудын түүх, угсаатны зүй, хууль цааз, шашин, хэл, соёлд холбогдох гар бичмэл, архивын баримт, гэрэл зургуудын талаар шинэ судалгаанууд танилцуулагдсан. Түүнчлэн түрэг судлал, Төв Азийн судалгааны хүрээнд сонирхолтой илтгэлүүд хэлэлцэгдэв.

Цахим хуралд монгол судлаачид олон газраас өргөнөөр оролцсон. Монгол судлалын тэргүүлэх төвүүдийн төлөөлөл оролцсон нь уг хурлын ач холбогдол ихээхэн анхаарал татаж, зөвхөн Монгол, Оросын эрдэмтдийн хүрээнд хязгаарлагдахгүй болсныг харуулна. Тус хуралд

Г.Алтансүх “Аноним Шибани наме дахь монгол хүний нэрийтгэл”, Э.Баярчимэг Лхаарамба Агваандандарын “Сарны гэгээн гэрэл” дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай, Л.Ганбат Ибн Арабшахын “АСÂÏBU’L MAKDÛR” зохиол дахь нүүдэлчдийн байлдааны арга ухааны тухай, И.М.Захарова, М.В.Мандрик нар 1870-1871 онд Хятадад аялсан ах дүү Бутиныхны шинжилгээний ангийн тухай, Э.Мөнхцэцэг Манж-Монгол толь бичгийн Улсын Номын сан дахь цуглуулга, хувилбаруудын тухай, Б.Нацагдорж, О.Оюунжаргал нар “Манж Чингийн үеийн Хүрээний хэргийн зүй” хэмээх баримтын тухай, И.В.Кульганек, Н.В.Захарова нар Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн сан хөмрөгт буй Монгол орон, монголчуудтай холбоотой гэрэл зургийн цуглуулгаар тус тус сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Монгол хэл, утга зохиолын дурсгал бичиг, архивын баримтын тухай Л.С.Дампилова 1967 оны шинжилгээний ангийн тайлан, Б.-Х.Б.Цыбикова Буриадын Шоно баатарын тухай, Д.А.Носов 1925 оны Казакевичийн тайлангийн тэмдэглэлээс, М.В.Федорова 1910 оны Д.Э.Ухтомскийн угсаатны зүйн цуглуулгын тухай, Т.И.Юсупова Зөвлөлтийн эрдэмтдийн тэмдэглэл, дүгнэлт дэх Монголын Судар бичгийн хүрээлэнгийн тухай өгүүлжээ. Ялангуяа эрдэмтэн Т.И.Юсупова 1920-1940-өөд оны үед Монголд ажилласан зөвлөлтийн эрдэмтэд БНМАУ-ын Судар бичгийн хүрээлэнгийн тухай хэрхэн өгүүлж, үнэлж байсныг тусгайлан судалсан нь тухайн үед дөнгөж байгуулагдаж байсан хожмын Монголын шинжлэх ухааны томоохон тулгуур төв Шинжлэх Ухааны Академийн талаарх бодит дүгнэлтийг тодруулан гаргасанд оршино. Эдгээрээс гадна К.И.Бикмаева Монгол улсад явуулж буй Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр болон төрийн бодлогын тухай, Р.Ю. Почекаев монголчуудын эрх зүйн үзэл санааны тухай, Э.Пүрэвжав судалгааны бүтээлүүдийн хувь заяа, хэлмэгдүүлэлтийн тухай, Т.Д.Скрынникова засаглалын сакраль байдал, түүний үүргийн тухай “Алтан товч” сурвалжийн мэдээгээр, А.Д.Цендина академич Ц.Дамдинсүрэн, Р.Отгонбаатар нарын цуглуулга дахь маанийн шооны тухай сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн билээ. Мөн Н.Хатанбаатар бидний Говь нутгаас олдсон XVII зууны үйсэн бичгийн дурсгалын тухай илтгэл багтсан юм.

Энэхүү эмхэтгэл нь Орос, Монголын эрдэмтэн судлаачдын архивын баримт, гар бичмэл, биет өвийн тухай олон сонирхолтой, шинэлэг өгүүлэлүүд орсон бүтээл болсон юм. Уг хурлыг зохион байгуулах ажлыг

удирдаж хийсэн И.В.Кульганек, Н.Хишигт нарт чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Цаашид энэ хамтын ажиллагаа улам өргөжиж “Монголчуудын соёлын өв: гар бичмэл, архивын баримтын цуглуулга” олон улсын эрдэм шинжилгээний хурлын цар хүрээ тэлж дэлхийн монгол судлалд томоохон байр суурь эзлэн, олон олон шинэ баримт, мэдээлэл судалгааны эргэлтэд орж, сурвалж бичиг, архивын баримт, гар бичмэлийн нарийн мэргэжлийн боловсон хүчин олноор төрнө гэдэгт итгэж байна.

Чингис хаан Үндэсний музейн захирал,
Олон Улсын Монгол Судлалын Холбооны
Ерөнхий нарийн бичгийн дарга, академич С.Чулуун



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ.
Международная конференция при поддержке Президента Монголии
19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

ПРИВЕТСТВИЕ
ДИРЕКТОРА ИНСТИТУТА ВОСТОЧНЫХ РУКОПИСЕЙ РАН,
ЧЛЕН-КОРРЕСПОНДЕНТА РАН И.Ф. ПОПОВОЙ

Дорогие участники постоянной Международной конференции
«Культурное наследие монголов: рукописные и архивные собрания»

Разрешите приветствовать Вас на важном и знаковом для международного научного сообщества мероприятии, которое является уже пятой конференцией с апреля 2013 года, организуемой в рамках Договора, подписанного между Институтом восточных рукописей РАН и Институтом истории и этнологии Монгольской Академии наук.

Первые две конференции данной тематики проходили при поддержке Президента Монголии Цахиагийн Элбэгдоржа. В настоящее время Президент Монголии Халтмаагийн Баттулга, а также Правительство Монголии в лице руководства Министерства образования и науки Монголии продолжают уделять большое внимание монголоведческим исследованиям во всем мире, способствуют постоянным международным научным контактам, что благоприятно влияет на российско-монгольское сотрудничество в целом и приносит значительные многосторонние результаты.

За период с 2013 года были изданы сборники материалов предыдущих конференций, проведенных при участии ИВР РАН и монгольских научных институтов, а также ряд сборников трудов, посвященных научному творчеству российских монголоведов (З.К. Касьяненко, Б.Я. Владимирцова, С.Г. Кляшторного).

В постоянных конференциях «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания» приняли участие ученые из России, Монголии, Китая, Японии, Венгрии, Польши. Доклады участников были посвящены проблемам изучения рукописных и архивных материалов, развития источниковедения как одного из ведущих направлений мирового монголоведения. На конференциях традиционно затрагивалось множество проблем, касающихся изучения разных сторон жизни и культурного наследия монголов. Особое внимание уделяется коллекциям Санкт-Петербурга и Улан-Батора, где хранятся уникальные рукописные и архивные памятники богатейшего духовного и культурного наследия монгольского народа, которое сформировалось на обширной территории Центральной Азии в

результате взаимодействия носителей разных хозяйственных укладов, культурных традиций, духовных ценностей и стало подтверждением этнокультурной и национальной идентичности, предметом гордости, солидарности и патриотизма монголов.

Актуальность конференций подтверждается активным обсуждением, сопровождающим каждое выступление. Наибольший интерес в настоящее время вызывают такие вопросы исторического источниковедения, как открытие новых имен в монголоведении и ранее не изучавшихся памятников культурного наследия монгольских народов.

Ценным является обмен мнениями о методах хранения рукописей и о возможности совместного изучения архивных материалов, находящихся в хранилищах разных стран. Ряд предложений по международным проектам о введении в научный оборот и издании материалов по истории монголоведения уже осуществлен.

Постоянная конференция «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания» имеет большое значение для дальнейших исследований истории, культуры и языка монгольских народов на основе письменных памятников и архивных источников, а также для объединения усилий специалистов в проведении совместных исследований с учетом новых междисциплинарных методов. Данное мероприятие демонстрирует новые возможности для введения в научный оборот культурного наследия монголов, подготовки молодых исследователей, создания совместных научных трудов, серийного издания монгольских письменных памятников, проведения специальных симпозиумов.

Я желаю всем участникам Конференции творческих успехов, новых плодотворных идей и процветания!

Директор Института восточных рукописей РАН,
член-корреспондент Российской академии наук И.Ф. Попова

**МОНГОЛ УЛСЫН
ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ,
АКАДЕМИЧ Д.РЭГДЭЛИЙН МЭНДЧИЛГЭЭ**

ЭРХЭМ ХҮНДЭТ ХАТАГТАЙ И.Ф.ПОПОВА
ЭРХЭМ ХҮНДЭТ ЭЛЧИН САЙД Д.ДАВАА
ЭРДЭМТЭН СУДЛААЧИД АА

“Монголчуудын өв соёл: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” сэдэвт 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын нээлтийг тохиолдуулан Та бүхэнд Монгол Улсын ШУА-ийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Энэхүү 5 дахь удаагийн хурал нь Монгол, Орос улсуудын хооронд дипломат харицаа тогтоосны 100, Судар бичгийн хүрээлэн байгуулагдсаны 100, манай ШУА байгуулагдсаны 60 жил зэрэг түүхэн ойннуудын жил болж байгаагаараа онцлог юм.

1921 онд тэр үеийн Монголын нийслэл Өргөө хотноо Судар бичгийн хүрээлэнг байгуулсан явдал бол манай оронд орчин үеийн шинжлэх ухааны байгууллага, түүний дотор манай улсын Шинжлэх ухааны Академи үүсэн хөгжих их үйл хэргийн эхлэл байсныг Та бид сайн мэднэ. Манай улсад шинжлэх ухааны салбар, эрдэм шинжилгээний байгууллага үүсэн бий болох, өсөн төлжих, өргөжин хөгжих бүхий л хугацаанд ЗХУ, Зөвлөлтийн шинжлэх ухааны нэр хүндтэй зохион байгуулагчид, алдартай монголч эрдэмтэд томоохон үүрэг гүйцэтгэж ирснийг баяртайгаар талархан санаж явдаг билээ.

Энэхүү эрдэм шинжилгээний цуврал хурлуудын гол зохион байгуулагчид болох Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Олон улсын монгол судлалын холбоо нь манай улсуудын эрдмийн хүрээлэнгүүд хоорондын найрсаг хамтын ажиллагааны түүхэн уламжлалыг амжилттай үргэлжлүүлэн, Монгол угсаатнуудын түүх соёл, хэл утга зохиолыг судлах, хамтын ажиллагаагаар бүтээсэн шинэхэн мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр нэн бүтээлч ажиллаж байна гэж би ойлгодог. Тийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэмжлэг дор Та бүхний зохион байгуулдаг энэ хурал нь олон орны монгол судлаачдын сонирхол, хүчин чармайлтыг нэгтгэдэг эрдэм

судлалын томоохон арга хэмжээнүүдийн нэг болж тогтоод байгааг тэмдэглэн хэлэхэд нэн таатай байна.

Та бүхний олон жилийн хүчин зүтгэлийн маргахын аргагүй томоохон үр дүн бол олон тооны гар бичмэлүүд, ксилографууд, түүний дотор Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, ОХУ-ын архив, музейнүүдийн онцгой ховор эх сурвалж, материалуудыг даян дэлхийн шинжлэх ухааны олон нийтийн хүртээл болгож, эрдэм оюуны эргэлтэнд оруулсан явдал билээ.

Энэ удаагийн хурлын хөтөлбөрөөс хуралд тэргүүлэх эрдэмтэд, залуу эрдэмтэн судлаачид олноор оролцож, өргөн хүрээний асуудлыг хэлэлцүүлэхээр байгаа нь харагдаж байна. Эдгээр илтгэлүүд нь монгол судлалын салбарт эрдмийн шинэ, сонирхолтой мэдлэг бий болгох нь дамжиггүй биз ээ.

Энэ удаагийн монгол угсаатнуудын бичмэл сурвалжуудын асуудлаарх хурлын нэг зорилго бол Монголчуудын түүх, угсаатан судлал, хэл, соёл, утга зохиол судлалын өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх явдал агаад Та бүхний дэвшүүлэн тавих шинэ санаа, таамаглалууд эдгээр чиглэлийн цаашдын хөгжил, чиг хандлагыг шинэ төвшинд гаргаж, улмаар дэлхийн монгол судлалын салбарт ажилладаг эрдэмтэн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, холбоо хэлхээг өргөжүүлэн бэхжүүлнэ гэдэгт би итгэж байна.

Мөн түүнчлэн энэхүү 5 дахь удаагийн хурал монголчуудын угсаа гарал, хэл, түүх, угсаатны зүй, соёл, аман зохиолд холбогдох олон шинэ, урд өмнө мэдэгдээгүй байсан эх сурвалж, баримтыг дэлхийн шинжлэх ухааны олон нийтэд хүргэх үндсэн зорилгодоо хүрнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Хүн төрөлхтнийг хамарсан цар тахлын хүнд үед бэлтгэлийг сайтар хангаж, уламжлалт арга хэмжээгээ амжилттай зохион байгуулсан бүх хүн, байгууллагад гүн талархал дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэн ерөөе.

Анхаарлаа хандуулж сонссон Та бүхэнд баярлалаа.

ПРИВЕТСТВИЕ
ГЕНЕРАЛЬНОГО СЕКРЕТАРЯ
МЕЖДУНАРОДНОЙ АССОЦИАЦИИ МОНГОЛОВЕДОВ,
АКАДЕМИКА С.ЧУЛУУНА

ДОРОГИЕ ДРУЗЬЯ
УВАЖАЕМЫЕ УЧЕНЫЕ

Я искренне рад снова даться с Вами и поблагодарить за участие в 5-й Международной научной конференции «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организуемой под эгидой Президента Монголии с 2013 года.

Как известно, первоначальная идея организовать совместную конференцию по источникам и документам была предложена российскими монголооведами во время визита Президента Монголии в г.Санкт-Петербург в мае 2011 г.

Инициатива была поддержана Институтом истории Монгольской Академии наук, который организовал в 2013 г. первую конференцию. С тех пор наша совместная конференция организовывалась под названием «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания» и поочередно проходила в Улан-Баторе и Санкт-Петербурге, вызывая широкий интерес ученых и исследователей, работающих в области монголоведения. Свидетельством тому явилась вторая конференция, с которой содержание и тематика наших совместных конференций были значительно расширены. Иными словами, в конференции стали принимать участие ученые и исследователи из других стран, представляя интереснейшие доклады об исторических источниках и архивных документах по истории и культурному наследию монголов, хранящихся в разных государствах мира. Это привело нас подумать над тем, чтобы не ограничиваться лишь нашими рамками - Улан-Батором и Санкт-Петербургом.

За прошедший период, в гг. Улан-Батор и Санкт-Петербург состоялись уже 4 конференции, материалы которых опубликовались в известных нам сборниках. Только в этот раз, из за непростой ситуации пандемии, несколько задержалась публикация сборника докладов IV конференции, но очень скоро он выйдет в свет.

Приятно подчеркнуть, что непосредственное участие в нашей конференции известных ученых и ведущих научных учреждений в области исследования истории, культуры, языка и литературы, изучения первоисточников и архивных документов по Монголии всех периодов, несомненно поднимает авторитет и статус международной конференции. Отрадно отметить, что сегодня представители самых разных областей мирового монголоведения весьма заинтересованы этим научным мероприятием нашей совместной деятельности и активно участвуют в ней.

Считая, что настоящая конференция имеет важное значение для изучения и обогащения культурного наследия монголов, расширения монголо-российских научных связей, дальнейшей активизации сотрудничества между учеными и исследователями, хочу выразить свою особую признательность и благодарность научному коллективу Института восточных рукописей РАН и Всем участникам конференции.


Хочу сказать, что Мы - главные организаторы конференции по культурному наследию монголов, приложим все усилия тому, чтобы проводимое нами научное мероприятие продолжалось вперед успешно и долго.

Я уверен в том, что пройдет сложный период пандемии, и очень скоро мы встретимся воочию, будем делиться научными новостями и обсуждать планы наших новых исследований.

Пользуясь случаем, следует сообщить Вам о перенесении срока проведения Международного Конгресса монголоведов на следующий -2022 год.

Желаю всем участникам успехов.

Генеральный секретарь
Международной ассоциации монголоведов,
академик С.Чулуун



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАРЫН МЭНДЧИЛГЭЭ



Mayor of Ulaanbaatar and Governor of the Capital city

Date: 16.04.2021

№: 01/21

Многоуважаемые организаторы и участники, Многоуважаемые дамы и господа разрешите приветствовать Вас от имени жителей города Улан-Батора и от себя лично с открытием пятой Международной конференции «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», который проходит в городе Санкт-Петербурге, чрезвычайно важном и знающем для международного научного сообщества мероприятии.

Приятно отметить, что город Санкт-Петербург по праву считается ведущим мировым центром монголоведения. Институт восточных рукописей РАН принимает активное участие в мероприятиях, проводимых в рамках культурного и научного сотрудничества между нашими городами: Улан-Батором и Санкт-Петербургом. Во время "Дней Санкт-Петербурга в Улан-Баторе" сотрудники ИВР РАН организовали в Музее истории и этнографии выставку редких рукописей из фонда своего Института. Во время "Дней культуры города Улан-Батора в Санкт-Петербурге" ИВР РАН провел также встречу Круглого стола среди международных представителей, на котором обсуждались вопросы российско-монгольского культурного взаимодействия.

Правительство Монголии продолжает уделять большое внимание международным монголоведным исследованиям, также способствует постоянным научным контактам, что благоприятно влияет на научное российско-монгольское сотрудничество и приносит положительные результаты. Благодаря совместной изыскательской работе уланбаторских и петербургских исследователей открыты новые имена в монголоведении и памятники культурного наследия монгольскими народами.

Актуальность конференции подтверждается тем, что она проходит в юбилейный год 100 летия установления дипломатических отношений между Монголией и Россией. Также в 2021 году мы отмечаем образование Ученого Совета Монголии.

Я желаю участникам Конференции продуктивной работы, интересных докладов и активного обсуждения и решения проблем, которые предстоит перед нами.

Желаю всем творческих успехов, благополучия и счастья!

ГУБЕРНАТОР СТОЛИЦЫ МОНГОЛИИ
МЭР ГОРОДА УЛАН-БАТОРА

Д.СУМЪЯАБАЗАР ДОЛГОРСУРОН

*Julius D. Ulaanbaatar square 7, Chingeltei District, 15169 Ulaanbaatar, Mongolia
Tel: +976-11-329639 / 329382, Fax: +976-11-324331*

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

DOI 10.48612/IVRRAN/uxrp-anh4-dn6r

Г.Алтансүх

АНОНИМ ШИБАНИ НĀМЕ ДАХЬ МОНГОЛ ХҮНИЙ НЭРИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Судалгааны дүнгээс үзэхэд энэ сурвалжид гар бичмэлд ойролцоо зурлагатай үсгүүдийг андуурсны зэрэгцээ хоорондоо нэг цэгийн ялгаатай бичигддэг үсгүүдийг мөн андуурч уншсанаас үүдэлтэй алдаанууд нийтлэг байна. Тиймээс Аноним Шибани нāме-г Чингис хаан ба түүний өвөг дээдсийн нэрийн талаар өөр хувилбарыг өгч буй сурвалж гэж үзэх боломжгүй юм.

Шибани нāме сурвалжийн зохиогч, хуулан бичигч нар перс сурвалжуудад байгаа монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг алдаж уншсан, түүний цэг дуслыг андуурсан алдаанууд гаргаснаас үүдэлтэй тус сурвалжийн судалгаанд зарим ойлгомжгүй байдлууд үүсэж, тодорхой бэрхшээл тулгардаг. Энэ нь Монголын түүх, монгол хүний нэрийн тогтолцоог сайн мэдэхгүй залуу судлаачдын хувьд тодорхой бэрхшээл болдог. Тиймээс энэ сурвалжид тэмдэглэгдсэн монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг Судрын чуулган болон Монголын нууц товчоон зэрэг сурвалжтай тулган нягтлах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: нэр судлал, нэр, оноосон нэр, газрын нэр, овгийн нэр

G.Altansukh

ON THE SOME ISSUES OF MONGOLIAN PERSONAL NAMES IN ANONYMOUS SHIBANI NĀME

According to the research results, mistakes caused by misreading of letters with close strokes as well as letters that differ by one point from each other are common in handwriting. Therefore, the Anonymous Shibani nāme is cannot be considered as a source providing an alternative version of the names of Genghis Khan and his ancestors. Some ambiguities arise in the research of this source, caused by the fact that the scribes who wrote the Shibani nāme source misread the name of the Mongolian person, the name of the land, the name of the tribe in the Persian sources, and confused the punctuation. In particular, it is a problem for young researchers who are not know with Mongolian history and the name system of Mongolian persons. Therefore, it is necessary to verify the names of

Mongolian persons, names of places, and tribes recorded in this source with sources such as the Jami'ut-tawarikh and The Secret History of the Mongols.

Key words: onomastic, name, given name, place name, family name.

Цагадай хэл бол түрэг төрлийн хэлүүдээс Дундад Азийн бүлэгт хамаардаг, XV зууны эхнээс XX зууны эхэн хүртэл идэвхитэй хэрэглэгдэж байсан утга зохиолын хэл юм. Өнөөгийн түрэг хэлүүдээс Өзбек хэл ба Шинэ уйгур хэлтэй ойролцоо. Судлаачдын бичсэнээс тоймлон үзвэл, Дундад Азид монголчуудын засаглал тогтохоос өмнө хорезм түрэг хэл, кипчак түрэг хэл гэсэн үндсэн хоёр салбар аялгуу байжээ. Харин монголчуудын байлдан дагууллын дүнд тэр газар нутагт Цагадайн улс байгуулагдсанаар кипчак, хорезм зэрэг түрэг хэлний салбар аялгууныуд ижилсэн нийлж утга зохиолын шинэ хэл үүссэн нь цагадай хэл юм.

Цагадай хэлээр бичиж үлдээсэн Монголын түүхийн сурвалжууд нэлээдгүй байдаг. Гэвч тэдгээр сурвалжийн судалгаанд тулгарч байдаг нэг асуудал нь монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг ихээхэн зөрүүтэй бичсэн явдал юм. Энэ нь тухайн сурвалжийн зохиогчийн болон хуулан бичээч нарын хариуцлага, ур чадварын асуудал мөн боловч тодорхой түүхэн нөхцөл шалтгаантай байдаг.

Цагадайн улс задран унахдаа эхлээд Мавераннахр болон Моголистан [Талас голын зүүн талын нутаг өөрөөр хэлбэл Туркестан болон Сэмирэч] гэсэн хоёр хэсэгт хуваагдсан байна. 1360 онд Тутлугтөмөр буцаан нэгтгэсэн боловч 1363 онд түүнийг нас барсны дараахан Цагадайн улсын үндсэн хэсэг эмир Төмөрийн мэдэлд оржээ [Grousset 1980. pp. 397-420]. 1370 оны 04 сарын 10 өдөр Балх хотод Төмөр өөрийгөө хаан өргөмжилснөөр түүхэн зохиолуудыг перс хэлээр бичих болов. Гэвч Эмир Төмөрийн байлдан дагуулаар байгуулсан улс XVI зууны эхэн үед [1507] задран унахтай зэрэгцэн Чингис хааны ууган хөвүүн Жүчи ханы шууд удмын Мухаммед Шибан хан Мавернахрыг эзлэн авч өөрийн улсыг байгуулсан байна. Тэгээд Шибан хан өөрийнхөө ялалтын түүхийг үр хойчистоо зориулан цагадай хэлээр бичих зарлиг буулгажээ. Энэ зарлигийн дагуу бичсэн түүхэн зохиолуудын нэг нь бидний сонирхон буй Шибани наме мөн юм.

Шибани наме хэмээн нэрлэдэг хэд хэдэн сурвалж байна. Үүний нэг нь түүх бичлэгт аноним буюу зохиогч нь тодорхойгүй Шибани наме хэмээн нэрлэдэг түүхэн сурвалж юм. Энэ сурвалжийн нэг гар бичмэл эдүгээ ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнд С-139 бүртгэлийн дугаартай хадгалагдаж байна. Тус сурвалжийг хэн,

хэзээ бичсэн тухай тодорхой мэдээлэл байхгүй. Гэхдээ Абулхайр ханы ураг удмыг 1530 он хүртэл бичсэнээс үзвэл XVI гучаад оноос хойш бичсэн нь лавтай юм. Гар бичмэлийн төгсгөл хэсэгт бичсэн газрыг нь *temmetü al-risale šerife fi valayit buhara* “Энэхүү жижиг номыг Бухар мужид бичиж төгсгөв.” хэмээн заажээ.

XVI зууны үе гэхэд Мавернахр болон Туркестаны бүс нутагт монгол хэлний хүч нөлөө буурч, монгол хэл, Монголын түүхийг сайн мэдэх хүн цөөрч байв. Тиймээс XVI зууны эхэн үеэс цагадай хэлээр бичих болсон түүхийн зохиолуудад өмнөх үеийн монголчуудын хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг буруу бичих нь нэлээд түгээмэл болжээ. Энэ байдлыг Абул Гази Бахадур хан “Шежере-и Турк” зохиолдоо “... Энэ зохиолыг бичихэд Судрын чуулган надад байсан. Түүнээс гадна Чингис хааны намтар түүхэнд холбогдох 17 ном байна. Тэдгээрт тулгуурлан номоо бичлээ. Судрын чуулган бичигдээд 372 жил өнгөрчээ. Миний гарт түүний 20-30 эх байх боловч тэд бүгдээр хуулан бичигч нарын зүгээс оруулсан ялгаа, алдаа ихтэй байна. Энэхүү түүхэн зохиолын уул, усны төдийгүй хүний нэр монгол хэлээр эсвэл түрэг хэлээр бичигджээ. Харин хуулан бичигч нар ихэвчлэн перс эсвэл тажик хүмүүс байдаг. Тэд монгол хэл, түрэг хэлийг огт мэдэхгүй. Тиймээс монгол нэрүүдийг тэдэнд 10 өдөр заасан ч огт ойлгохгүй юм. Тиймээс тэд энэ номыг яаж ч зөв хуулан бичих билээ” хэмээн тодорхойлсон байдаг [Ebu'l-Gazi Bahadır Han 2009.s. 38-39]. Тоймлон хэлбэл, XVI-XVII зууны үед цагадай хэлээр бичигдсэн түүхэн сурвалжуудын тулгуур эх хэрэглэгдэхүүн нь Судрын чуулган тэргүүтэй перс сурвалжууд байсан боловч тэдгээр перс сурвалжуудад буй монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг зөв хуулан бичих нь ихээхэн хүчир болсон байжээ.

Бидний хэлэлцэн буй Шибани наме бол XVI зууны дунд үед монгол хэл сайн мэдэхгүй хүний бичсэн түүхэн зохиол бөгөөд Абул Гази Бахадур ханы тодорхойлсон тус алдаа мэдгийн тод жишээ болохуйц сурвалж юм.

Шибаны наме сурвалж нь үндсэн гурван хэсэгтэй:

1. Адамаас эхлээд Чингис хааны үе хүртэлх хэсэг
2. Хонгират иргэний түүхэнд холбогдох хэсэг
3. Шибан ханы түүхийн хэсэг

Эдгээрээс нэгдүгээр хэсэгт тэмдэглэгсэн монгол хүний нэрүүдэд нэлээд алдаа гарсан учир энэ илтгэлийн хүрээнд нэгдүгээр хэсэгт буй монгол хэлний оноосон нэрүүдэд гарсан нийтлэг алдаа, түүнээс урган гарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын тухай товч өгүүлнэ.

Хүний нэр:

Зөрүүтэй бичсэн зарим нэрс

1. Эхэд لارم یتوق *Quti maral* хэмээн бичсэн байна [96a, 13]. Судрын чуулганд тус нэрийг لارم أوق *Qua maral* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373, s.218] бол Монголын нууц товчоонд 騰格^{ᠲᠦᠭᠦᠷᠢᠯ}額扯 *Qo'ai maral* хэмээн бичдэг [§ 1].

2. Эхэд тус нэрийн ائىق یتوق *Otči qıyan* хэмээн бичжээ [96b, 01]. Харин Судрын чуулганд ائىق یتوق *Batači qa'an* гэж бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.218]. Монголын нууц товчоонд 巴塔赤罕 *Batačiqan* хэмээн бичсэн байдаг [§ 1, 2].

3. Эхэд ائىق یتوق *Eriken* гэж бичсэн байна [99a, 11]. Монголын нууц товчоонд 抄真幹児帖該 *Čaujin örtegei* хэмээн 2 удаа тэмдэглэжээ [§ 47(2)]. Түүний нэрийг Судрын чуулганд ائىق یتوق *Ja'učin*, ائىق یتوق *Ja'učin* гэж бичсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.238].

4. Эхэд گنس وک اکروک *Šing-kükürken* хэмээн бичсэн [106b, 09] бол Судрын чуулганд тус нэрийг گنس وک اکروک *Čikü kürgen* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.160]. Монголын нууц товчоонд 赤古古^{ᠴᠢᠭᠦᠷᠭᠡᠨ}列堅 *Čigü güregen* хэмээн бичсэн байна [§ 202].

5. Эхэд سمس یتوق *Semsa'uci* гэж бичжээ [96b, 04]. Судрын чуулганд тус нэрийг سمس یتوق *Semsoči* хэмээн тодорхой бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.219] бол Монголын нууц товчоонд 掃鎖赤 *Semsoči* хэмээн бичжээ [§ 2].

6. Эхэд سمس یتوق *Bosqin salcı* хэмээн бичжээ [98a, 04]. Судрын чуулганд уг нэрийг سمس یتوق *Buqatu salaci* [Rešidüddin Fazlullah 1373. s.223], Монголын нууц товчоонд 不^ᠨ忽^{ᠬᠤ}秃^{ᠲᠤ}撒^{ᠰᠠ}只 *Buqutu salji* хэмээн бичсэн байдаг [§ 42].

7. Эхэд اکرم و ح یتوق *Qubaḥu merken* хэмээн бичсэн байна [96b, 02]. Энэ нэрийг Судрын чуулганд ائىق یتوق *Qoričar mergen* хэмээн бичдэг [Rešidüddin Fazlullah 1373. s.218] бол Монголын нууц товчоонд 豁^{ᠬᠤᠰᠠ}里^{ᠯᠢ}察^{ᠴᠠ}児^{ᠡᠷᠢ}篋^{ᠨᠢ}干 *Qoričar mergen* хэмээн бичдэг [§ 2]. Энд Судрын чуулганд тэмдэглэгдсэн монгол хүний нэрийг уншихдаа үсэг, цэг тэмдэг зөрүүлэн уншсан нь илэрхий байна. Тухайлбал, ائىق یتوق нэрийн ى үсгийг و үсгээр андуурсан, ح үсгийг چ үсгээр андуурсан байгаа юм. Энэ нь Судрын чуулганы зарим эхэд энэхүү эгшиг ялгах тэмдэг тавиагүй байдагтай холбоотой.

8. Эхэд یتوق یتوق *Yuqun qataqi* хэмээн бичжээ [98a, 03]. Судрын чуулганд тус нэрийг یتوق یتوق *Buqun qataqi* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.183] бол Монголын нууц товчоонд 不^ᠨ忽^{ᠬᠤ}中^{ᠵᠤ}合

塔吉 *Buquqatagi* хэмээн бичсэн буй [§ 19]. Харин тус эхэд нэрийн эхний б үсгийн цэгийг андуурч уншсан бололтой байна.

9. Эхэд رچنڭزوب *Bozančar* хэмээн бичжээ [98a, 11]. Энэ нэрийг Судрын чуулганд رچنڭزوب *Bodunčar* хэмээн бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.227]. Харин Монголын нууц товчоонд 孛端察兒 *Bodončar* гэж бичдэг [§ 17]. Судрын чуулганы رچنڭزوب нэрийн ڊ үсэгний дээд талын эгшиг ялгах тэмдгийг цэгтэй андуурч уншсан бололтой.

10. Эхэд دوكؤا *Üküid* гэж бичсэн бол Судрын чуулганд энэ үгийг روكؤا *Buda üküir* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.241]. Судрын чуулган дахь нэрийн төгсгөлд буй ɔ үсгийг ڊ хэмээн андуурсан нь илэрхий байна. И.Березин харин Угудъ хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXXI].

11. Эхэд قاغوب نىكوا *Ökin buyaq* гэж бичсэн байна [99b, 9]. Монголын нууц товчоонд тус нэрийг 斡勤巴兒^{中合} *Ökin-barqaq* гэж бичсэн [§ 48] бол Судрын чуулганд قاقرب نىكوا *Ökin barqaq* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. Эхэд тус нэрийг ɔ үсгийг ɔ үсэгтэй андуурч бичсэн нь тодорхой байна.

12. Эхэд رداہ اتروب *Burta bahadır* гэж бичжээ [99b, 10]. Мөн тус сурвалжийн 29-9, 10-т رداہ انترب *Bartan bahadır* гэж бичсэн байна. Монголын нууц товчоонд тус нэрийг 把兒壇把阿禿兒 *Bartan ba'atur* гэсэн [§ 48] бол Судрын чуулганд رڭاب انترب *Bartan bahadur* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.268]. Мөн уг нэрийн ɔ үсгийг ɔ үсэгтэй андуурч бичсэн бололтой.

13. Эхэд نىكچنوا نادوت *Töden-oncikin* хэмээн бичжээ [99b, 15]. Уг нэрийг Монголын нууц товчоонд 脫朵延斡^楊 赤斤 *Tödö'en-o[t] cigin* хэмээн бичжээ [§ 48]. Судрын чуулганд نىكچتوا ناگوتوت *Tödügen otčgin* гэжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. Уг эхэд ن үсгийг ن үсэгтэй андуурсан байна.

14. Эхэд نىكىب نىجوف *Fücin biki* хэмээн бичжээ [109b, 02]. Судрын чуулганд тус нэрийг نىجوق نىكىب *Qocin biki* [Rešidüddin Fazlullah 1373. s.161], Монголын нууц товчоонд 豁真別乞 *Qojin beki* гэжээ [§ 165]. Энд нэрийн эхэн дэх ق үсгийг ف үсэгтэй андуурчээ.

15. Эхэд اوكنم وتق وى وقا *Aquyuqutu möngür* гэж бичжээ [99b, 12]. Тус нэрийн Монголын нууц товчоонд 中忽禿^黑 禿蒙古 *Qutuqtu-mönggür* хэмээн бичсэн [§ 48] бол Судрын чуулганд رلگنوم وتقوتوق *Qutuqtu möngler* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249].

16. Эхэд тус нэрийг له مكرت *Terke-ehil* хэмээн бичсэн [106a, 03] Судрын чуулганд тус хүний нэрийг له مكرت *Terge emel* гэж бичсэн байдаг

[Rešidüddin Fazlullah 1373. s.386]. Харин Монголын нууц товчоонд 迭^舌兒格額^克篋^勒 *Dergek emel* хэмээн бичжээ [§ 141]. Энд Судрын чуулганы эх дахь м үсгийг о үсгээр андуурч бичсэн нь тодорхой байна.

Сурвалж дотроо зөрүүтэй бичсэн нэрс

1. Эхэд энэ нэрийг хоёр янзаар бичсэн байна. Эхлээд نىم موتو^د *Dutum min* хэмээн бичжээ [98b, 03]. Дөрвөн мөрний дараа نىم موتو^د *Dutum menin* хэмээн бичсэн буй [98b, 07]. Судрын чуулганд энэ нэрийг мөн адил نىم موتو^د *Dutum menen* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.227]. Монголын нууц товчоонд 篋年土敦 *Menen tudun* хэмээсэн байна [§ 45]. Энэ нэрийн хувьд Судрын чуулган дахь نىم موتو^د нэрийн ن үсгийн доод талын эгшиг ялгах тэмдгийг хоёр цэг хэмээн андуурч уншсан бололтой.

2. Эхэд قىبلوق *Qubla*, قىبلوق *Qūbla*, قىتوق *Qutla* гэх зэргээр бичжээ [100b, 08, 09]. Монголын нууц товчоонд тус нэрийг 忽圖刺 *Qutula* хэмээн бичдэг [§ 48] бол Судрын чуулганд قىتوق *Qutula* гэж бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. И.Березин эхийг дагаж Гкубила Гкаан хэмээн бичжээ [Березнымъ1849. с. XXXIII].

Овог, аймгийн нэр.

1. Эхэд تونوقان *Anqunut* хэмээн бичжээ [102a, 14]. Гэвч Судрын чуулганд تونوقلوا^ا “Олхунут [Olqunut] иргэнээс гаралтай түүний нэр нь Сандагжин.” хэмээн өгүүлсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.280]. Энд зохиогч дээрээ цэгтэй ن үсгийг ن үсгээр андуурч уншсан бололтой. Гэтэл И.Березин эхийг баримталж ямар нэгэн тайлбаргүй *Анкономъ* гэж бичжээ [Березнымъ1849. с. XXXV]. Харин Якуф Карасой, Мустафа Токер нар тус нэрийг *Ankunut* хэмээн бичээд дунд үеийн нэгэн монгол аймгийн нэр хэмээн тайлбар хийжээ [Karasoy, Toker. 2005. s. 77, 112]

2. Эхэд نىجىروب *Borujcin* хэмээн бичсэн байна. Монголын нууц товчоонд тус нэрийг 孛兒只斤 *Borjigin* хэмээн бичсэн [§ 42] бол Судрын чуулганд نىجىروب *Borjiqin* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.270]. И.Березин эхийг дагаж *Буругкчинъ* гэжээ [Березнымъ 1849. с. XXXIV].

3. Эхэд توىجبات *Tabciut* хэмээн бичжээ [103b, 104a]. Энд Судрын чуулганы ن үсгийн хоёр цэгийг нэг цэгтэй андуурч ب болгож уншсан бололтой. Тус нэрийг Судрын чуулганд توىچىات *Taiči'ut* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.186]. Монголын нууц товчоонд 泰赤

ᠯ_揚 *Taiči'ut* гэж бичсэн байдаг [§ 72]. И.Березин эхийг дагаж *Табджіют* гэж бичсэн байна [Березнымъ 1849. с. XXXVI].

4. Эхэд *قانىلى* *Qanylı* хэмээн бичжээ [93b, 01]. Судрын чуулганд тус нэрийг *قانىلى* *Qanqli* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.52] бол Монголын нууц товчоонд тус нэрийг 中康鄰 *Kanglin* хэмээн тэмдэглэжээ [§ 270]. И.Березин тус нэрийг *Гконгголай* хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXIII].

5. Эхэд *گوجاغ* *Ayacıg* хэмээн бичжээ [93b, 02]. Судрын чуулганд тус нэрийг *چاچاغ* *Ayaçeri* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.53]. Эхэд тус нэрийн *چ* үсгийг *و* үсэг хэмээн андуурсан, мөн *ی* үсгийг *گ* үсэгтэй андуурсан бололтой байна. И.Березин тус нэрсийг Уйгурь, Гконгголай, Гкыпчагъ, Ххаладжъ, Аггаджукъ зэргээр уншжээ [Березнымъ 1849.с. XXIII]. Якуф Карасой, Мустафа Токер нар ямар нэгэн тайлбаргүй эхийг дагаж *Uygurlar, Kanghlar, Kırçaklar, Halaçlar, Ağaçükler* хэмээн бичсэн байна [Karaso, Toker 2005. s. 69]

Газар усны нэр

1. Эхэд *نوك منكزا* *Özkenk qın* хэмээн тэмдэглэжээ [95b, 07]. Судрын чуулганд тус газрын нэрийг *نوك منكزا* *Erkene qın* хэмээн бичсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.147]. Тус сурвалжийн зохиогч Судрын чуулганыг ашигласнаа хэдэн удаа давтан өгүүлсэн байна. Тэгэхдээ Судрын чуулганд *نوك منكزا* үгийн *چ* [r] үсгийн дээрх богино дуудлагын тэмдэгтийг цэгтэй андууран *ز* [z] хэмээн уншсан нь илэрхий байна. И.Березин тус нэрийг “Узгене Гкон” хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXVI]. Энэ нэрийн хоёрдугаар бүтэц болох *نوك* хэмээх үгийг *qon* эсвэл *qın* гэж унших бүрэн боломжтой боловч Монголын нууц товчоон дахь *Jorqal-qın, Naqu-qın, Sariq-qın, Quldaqar-qın* зэрэг уулын нэрээс дуудлагыг нь сэргээн унших боломжтой юм.

2. Эхэд *اتوا* *Otan* хэмээн бичжээ [96b, 07]. Энд *اتوا* *Onan* хэмээх үгийг уншихдаа цэг андуурч уншсан нь тодорхой байна. Судрын чуулганы яг энэ өгүүлбэрт тус голын нэрийг *اتوا* *Onan* хэмээн бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.219] бол Монголын нууц товчоонд 幹難 *Onan* хэмээн бичдэг [§ 1]. И.Березин эхийг баримталж “Отана” хэмээн бичжээ [Березнымъ 1849. с. XXVII]. Эхэд буй “Нутаг нь Отан [Онон], Хэрлэн, Туул ажээ.” гэсэн өгүүлбэрийг Якуф Карасой, Мустафа Токер “Тэдний нутаг бэлчээр сайтай бөгөөд гэрүүд нь тоосгоор барьсан.” хэмээн буруу орчуулжээ [Karaso, Toker 2005. s. 72]. Тэд тус гурван голын нэрийг цагадай хэлний үг хэмээн ойлгожээ.

Шибани нāме сурвалжид гарч буй Монгол хэлний оноосон нэрүүдэд гарч буй алдаа, зөрчлийг дээрх хэдэн жишээнээс тоймлон үзвэл дараах нийтлэг алдаанууд ажиглагдаж байна.

1. Нэрийн ب үсгийг ی үсгээр, ی үсгийг ب үсгээр андуурсан
 - 1 ی ی ق ت ق ن و ق ی *yuqun qataqi* ب ی ق ت ق ن و ق ی *buqun qataqi*
 - 2 ت و ی ج بات *tabciut* ت و ی چ ی ات *taiči 'ut*
2. Нэрийн ر үсгийг و үсгээр андуурсан, و үсгийг ر үсгээр андуурсан
 - 1 و ی ق ت ق ن و ق ی *quba hu merken* ر ی ق ت ق ن و ق ی *qoričar mergen*
 - 2 و ی ق ت ق ن و ق ی *ökin buyaq* ر ی ق ت ق ن و ق ی *ökin barqaq*
 - 3 ر د ا ب ات ر و ب *burta bahadır* ر د ا ب ت ا ت ر ب *bartan bahadur*
 - 4 ر ی ق ت ق ن و ق ی *ayačüig* ر ی ق ت ق ن و ق ی *ayačeri*
3. Нэрийн ت үсгийг ن үсгээр, ن үсгийг ت үсгээр андуурсан
 - 1 ن ی ق ت ق ن و ق ی *tudan-oncikin* ت ی ق ت ق ن و ق ی *tydygen otčgin*
 - 2 ن ی ق ت ق ن و ق ی *dariny otcikfn* ت ی ق ت ق ن و ق ی *daritay otčigin*
 - 3 ن ا ت و ا *otan* ن ا ن و ا *onan*
4. Нэрийн ق үсгийг ت үсгээр, ت үсгийг ق үсгээр андуурсан
 - 1 و ا د و ب س و ق *qusbuda 'u* و ا د و ب س و ت *tusbuda 'u*
 - 2 ت و ت و ق ت و ق *tutuqtu* و ت ق و ت و ق *qutuqtu*
5. Нэрийн ق үсгийг ف үсгээр, ف үсгийг ق үсгээр андуурсан
 - 1 ف ی ق ت ق ن و ق ی *öelün qocin* ق ی ق ت ق ن و ق ی *öelün füjin*
 - 2 ف ی ق ت ق ن و ق ی *fücin biki* ق ی ق ت ق ن و ق ی *qocin biki*

Тодорхой хэлбэл, гар бичмэлд ойролцоо зурлагатай үсгүүдийг андуурсны зэрэгцээ хоорондоо нэг цэгийн ялгаатай бичигддэг үсэгнүүдийг андуурч уншсанаас үүдэлтэй алдаанууд нийтлэг байна. Тиймээс Аноним Шибани нāме-г Чингис хаан ба түүний өвөг дээдсийн нэрийн талаар өөр хувилбарыг өгч буй сурвалж гэж үзэх боломжгүй юм. Шибани нāме сурвалжийн зохиогч, хуулан бичигч нар перс сурвалжуудад байгаа монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг алдаж уншсан, түүний цэг дуслыг андуурсан алдаанууд гаргаснаас үүдэлтэй тус сурвалжийн судалгаанд зарим ойлгомжгүй байдлууд үүсэж, тодорхой бэрхшээл тулгардаг. Тэр дундаа Монголын түүх, монгол хүний нэрийн тогтолцоог сайн мэдэхгүй залуу судлаачдын

хувьд тодорхой бэрхшээл болдог. Тиймээс энэ сурвалжид тэмдэглэгдсэн монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг Судрын чуулган болон Монголын нууц товчоонд гэх зэрэг сурвалжтай тулган нягтлаж алдааг нь засах, зөрүүтэй бичлэгүүдийг жигдлэх зайлшгүй шаардлагатай юм.

Ашигласан материал

1. Ebu'l-Gazi Bahadır Han 2009: -l-Gazi Bahadır Han Türk'ün Soy Ağacı Türk Şeceresi. Çağatay şivesinden Türkiye şivesine çeviren Rıza Nur. Günümüz Türkçesine Sadeleştiren Yunus Yiğit. İstanbul, 2009.
2. Rachewilts 1972: *Rachewilts I.de. Index to the Secret History of the Mongols.* Bloomington. 1972.
3. Rashiduddin Fazlullah 1998: *Rashiduddin Fazlullah. Jamī'ut-tawarikh: Compendium of Chronicles.* English translation and Annotation by W.M.Thackston. Part one. Harvard University. 1998
4. Grousset 1980: *Renū Grousset.* Bozkır İmparatorluğu. İstanbul. 1980.
5. ReşidüddinFazlullah1373:*Reşidüddin Fazlullah Hemedani.* Свми'ut-tevbroh. Tashih Muhammed Рыşen ve Mustafa Мыsevo. С.І, Enteşerat-i Elborz, Tahran.1373.
6. Karasoy, Toker 2005: *Yakup Karasoy, Mustafa Toker.* Türklerde Şecere Geleneği ve Anonim Şibanînâme.Konya. 2005.
7. Березнымъ 1849: *И.Березнымъ.* Шейбанада. История монголо – тюрковъ. Джагатайскомъ диалектѣ, съ переводомъ, примѣчаниями и приложениями. Казань. 1849.
8. www.mnuuts.net

DOI 10.48612/IVRRAN/fth2-v13r-a8dm

Э. Баярчимэг

**ЛХААРАМБА АГВААНДАНДАРЫН НАЙРУУЛСАН
“САРНЫ ГЭГЭЭН ГЭРЭЛ” ХЭМЭЭХ ДОХИОНЫ БИЧГИЙН
НЭГЭН ХУВИЛБАРЫН ТУХАЙ**

Олноо Алишаа лхаарамба, Дандар лхаарамба хэмээн алдаршсан, их эрдэмтэн Агваандандарын 1838 онд найруулсан төвөд үсгийн цагаан толгойн үсэг дараалуулсан “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршвой” (товч нэр: “Сарны гэгээн гэрэл”) хэмээх төвөд-монгол хоёр хэлний дохионы бичиг нь зохиогдсон цагаасаа хойш модон бараар төдийгүй мөн гар бичмэл хэлбэрээр ч тархсан байдаг. Тэгвэл ийм гар бичмэлийн нэгэн хувилбар болох төвөд-ойрад гар бичмэл эхийг Баруун хойтын үндэсний их сургуулийн багш Б.Мөнхөө, Монгол улсын боловсролын их сургуулийн багш На.Сүхбаатар нар 2018 онд Улаанбаатар хотноо гэрэл зургаар эрхлэн хэвлүүлж олон нийтэд танилцуулан судалгааны эргэлтэд оруулжээ. Уг хувилбар нь шаашиг номын хүрээнд тухайн уншигч, хэрэглэгчийн мэдлэгт тохируулж төвөд үсгээр ойрад аялгууг галиглан тэмдэглэснээрээ бусад хувилбараас онцлог ялгаатай байна. Зохиогч тус өгүүлэлдээ “Тод номын гэрэл төв”-өөс 2018 онд хэвлэн гаргасан уг төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл” толь бичгийн хэлний зарим онцлогийн тухай дурджээ. Мөн Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй А-0975 дугаартай “Ner-e udqa-a-yi todudqayçi saran-u gegen gerel kemegdekü dokiyan-u bičig orusiba” хэмээх эхийн төвөд үсгээр галигласан зарчмыг дээрх гар бичмэл хувилбартай харьцуулан үзжээ.

Түлхүүр үг: Толь бичиг, төвөд-ойрад хувилбар

E.Bayarchimeg

**ON A VERSION OF TIBETAN AND MONGOLIAN DICTIONARY
“BRIGHT MOONLIGHT” BY LHAARAMBA AGVAANDANDAR**

Tibetan-Mongolian dictionary called as “Ner-e udqa-yi todudqayçi saran-u gegen gerel kemegdekü dokiyan-u bičig orusiba” (briefly, “Bright Light of Moon”) that was written in 1838 by Agvaandandar, a great scholar known as “Alshaa lharamba” or “Dandar lharamba” had been published in wooden prints and manuscripts since its publication time. A version of the manuscripts was

published as photograph by Munkhuu B and Sukhbaatar Na in Ulaanbaatar in 2018. This version is peculiar in which Oirat dialect words were transcribed by Tibetan script adjusting to audience and readers.

*The author compares this version to the wooden print version kept numbered as A-0975 (Beijing print, 62p, 10*51.5, 4) in Mongolian book storeroom of the Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences and describes their phonetic, orthographic and morphologic features.*

Key words: Dictionary, Tibetan-Oirat version

Монголчуудын толь бичиг зохион хэрэглэж ирсэн түүхийг нэхэн үзвэл их л эртний улбаа гарах бөгөөд (Түвшинтөгс, 2008: 113) монголчууд бид эх хэлээрээ болон бусад хэлээр толь бичиг найруулж байсан баялаг түүхтэй, тэр дундаа төвөд бичгийн хэлээр толь найруулсаар ирсэн арвин туршлагатай ард түмэн билээ.

Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” дохионы бичгийг эрдэмтэд өөр өөрсдийн бүтээлдээ дараах байдлаар тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг.

“Гүн Гомбожавын даягийг бодвол нэлээд олон үгтэй бөгөөд үг үсэг нь алдаа мадаггүй, төвөд үсгийн дэс дараагаар зохиосон, орчуулга ч сайн. Нэр үгс ба үйл үгийн үндсийг зөвөөр гаргаж, нэр үгсийн утгыг орчуулгаар тодотгон харуулж чадсан болой” (Дорж, 2009: 109-110). “Төвөд хэлний үгсийн сангийн нэгжийн цөм утгыг монгол хэлнээ чадамгай буулган дохиолсон хамгийн шилдэг толь бичгийн нэг болж чадсан нь хожим хойшид, өнөө ч суралцагч оюутны эрэл хэрэгцээг хангасаар буй нь зохиогчийн хэрэг зориг бүрэн биелснийг илтгэнэ” (Сүхбаатар нар, 2018: VIII). “Толь зүйн чиглэлээр Агваандандар «Сарны гэрэл» хэмээх түм орчим үгийг багтаасан алдарт толь бичгээ туурвисан нь Ар, Өвөр монгол, ойрад, буриад мэргэдийн ширээний ном болсоор ирсэн төдийгүй өнөө цагийн хэл соёл судлаачдын чухал гарын авлага болж байна” (Бүрнээ, 2018: 6). “Агваандандар лхаарамба нь гүн Гомбожавын зохиосон дохионы бичигт буй дутуу үгсийг нөхөн гүйцээх замаар түүнээс хавьгүй олон үгтэй бие даасан дохионы бичиг найруулсан байна” (Даваасүрэн, 2018: 17) гэх мэтээр дүгнэсэн байдаг. Энэ мэт Агваандандарын “Сарны гэгээн гэрэл” хэмээх хоёр хэлний дохионы бичиг нь одоо ч судлаачдын төвөд-монгол толь бичиг найруулах үндсэн гарын авлагын нэг болсоор байгааг эрдэмтэн судлаачид дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрдөг байна.

“Сарны гэгээн гэрэл” хэмээх хоёр хэлний дохионы бичгийн нэгэн хувилбар болох төвөд-ойрад гар бичмэлээр байгаа эхийн хэлний баримт сэлтийг судлах нь монгол хэлний ойрад аялгууны авиа зүй, үг зүй, үгийн сангийн хувьсал хөгжил хийгээд тухайн үеийн ойрад аялгууны онцлог ямар байсан зэргийг судлахад нэлээд сонирхолтой эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.

Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй “Сарны гэгээн гэрэл” хэмээх барын эхийн эхний 21 нүүрэнд төвөд үсгээр монгол үгийг галиглан хадсан байгааг ажиглан тэдгээрийн үсэг зүй, авиа зүй, үг зүйн зарим онцлогийн талаар харьцуулан авч үзье.

Монголд эрт дээр үеэс уламжлан хөгжиж ирсэн аман бичгийн хэлний байдал хэрхэн өөрчлөгдөж энэхүү аман бичгийн хэл нь бичгийн хэл, ярианы хэл хоёрын харилцан нөлөөлөх явцад хэрхэн хөгжиж ирсний түүхийг судлахад бүр ч анхаарлыг татах гойд үнэтэй хэрэглэгдэхүүн болж өгнө (Пагба, 2009: 221) хэмээн төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиолын ач холбогдлын талаар өгүүлжээ.

Өнгөрсөн зууны гучаад он хүртэл Монгол газар буддын боловсролыг олгох зорилгоор өдий төдий хүрээ хийдүүд байгуулагдаж, тэнд төвөд хэлээр сургалт явуулдаг байсны улмаас төвөд бичгийн хэлний хэрэглээ өргөжсөн ажээ. Хүрээ хийдэд эрдэм ном суралцаж байсан хүмүүс өөр хоорондоо бичгээр харилцах, төвөд хэлийг сурч судлах, бурхны сургаал номлолыг бүрэн ухаарч ойлгоход монгол хэлээр бичиж тэмдэглэх хэрэгцээ заавал ч үгүй гарч ирэх нь мэдээж юм. Чухамхүү хэрэгцээг төвөд үсгээр монгол хэлийг үгчлэн буулгах замаар хангаж байжээ (Сүхбаатар нар, 2018: VIII) хэмээн дүгнэсэн байна. Тэгвэл эрдэмтэн Т.Пагба Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ: “... Төвдийн бичгийн хэлэнд нэвтэрхий мэргэжсэн монгол хүн хэдэн арван жил төвдийн бичиг зохиолд нас биеэ зориулаад, монгол бичгээ сурахыг хичээх нь цөөн байв. Төвөд цагаан толгой, зөв бичих дүрмийн наад захын томьёолол төдийхнийг мэдсэн тийм лам нараас аваад төвөд бичгийн хэлэнд гүнзгий мэргэжсэн бичгийн хүмүүст ч хүртэл харилцааны гол хэрэглүүр болсон хэлээ бичгээр илэрхийлэх шаардлага аяндаа гарч ирсэн аж. Жишээ нь, төвөд орчуулгын ном үзэхэд, төвөд хэлний үг, хэллэгийн утга учрыг мартахгүйн тул, орчуулгыг нь хадахдаа монгол бичиг мэдэхгүй учир төвөд үсгээр үгчилж тэмдэглэх нь аргагүй шаардагдав. Ийнхүү монгол үгийг төвөд үсгээр галигчлан бичих явдал урсгалаар гарч ирсэн бөгөөд

түүнийгээ “үгчлэх” гэж нэрлэдэг байв” хэмээн дурджээ. Өөрөөр хэлбэл төвөд үсэг бичиг сурсан, монгол бичиг үсгээ сураагүй лам нарт зориулсан төвөд үсгээр үгчлэн буулгасан дохионы бичгүүд болон бусад ном зохиол нэн олон гарсаар байсан тухай илтгэлдээ дурджээ.

“Нэр утгыг тодотгогч Сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршвой” толь бичгийн төвөд-ойрад гар бичмэл хувилбарын тухай

Баруун хойтын үндэсний их сургуулийн багш Б.Мөнхөө, Монгол улсын боловсролын их сургуулийн багш На.Сүхбаатар нарын 2018 онд гэрэл зургаар эрхлэн хэвлүүлсэн «Алшаа лхаарамба Агваандандар “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой»» номд танилцуулснаар:

Номын нэр: ༄༅།བརྒྱལ་ཡིག་མིང་དོན་གསལ་བར་བྱེད་པའི་སྒྲུབ་པའི་འོད་སྤྲེང་ཞེས་བྱ་བ་བརྒྱགས་སོ།

Хэмжээ: 35х10.5 см ХЭМЖЭЭТЭЙ

болгомол цаасан дээр 3 мөрөөр, хар бэхээр бичсэн төвөд-ойрад монгол гар бичмэл, 93 хуудастай байна.

Төгсгөлийн үг: төвөд үсгээр ойрад аялгуугаар – “Өгүүлэгдэхүүн утгын махны өнгийг үл халхлах, өгүүлэгч үгийн сайн үүнийг, элдэв үзгийн (үсгийн) олон ширхгийг эвлүүлж, билгийн хуруугаар сайтар нэхэж бүтээв би алимад дохио барилдуулах ёсонд эс мэргэжвээс, хоёр ёсны ялгалд мунхрах болоод, мэргэдийн сууринд суухуйяа зохисгүй тул, тэр ёсонд үл тэсэхдээ энэ учирт оролдвой. Энэ нь дуришилтны эрэл хангагч, сайн бумба хийгээд, сайн зарлигийн далайн сонин юмыг үзэх нүдэн, дохио утгын сайхан царай тодрогч толь бөгөөд, элдэв зүйлийн нэрийтгэлийг гийгүүлэгч

Зураг 1. “Сарны гэгээн гэрэл”-ийн
төгсгөлийн үгийн хэсгээс

зул мөн, аяа нэр утгыг тодотгогч сүр жавхлангаар, мунхгийн харанхуйг нэгэн агшинд үлдэгч, нарны гэрлээс ч асар тодорхой, чихний чимэг

үүнийг, бүгдээр дууны баригч байн, гийгүүлэх цог болгогтун, боловч хамаг номын магад үгсэд, очтой гэгээн тод билиг олсонгүйн тул, мэдэлгүй буруу номносон гэмээр халдсан болбоос, энэрэн хүлцэж шамдлаар ясан (засан) ажаамуй, үүнд хичээсэн буяны мэргэн их худалдаачны ноён тэр” гэж орчуулаад цааш орчуулалгүй орхисныг На.Сүхбаатар нарын гэрэл зургаар хэвлүүлсэн бүтээлд кирилл монгол болон тод монгол үсгээр орчуулан гаргасан байна.

**“Сарны гэгээн гэрэл” хэмээх төвөд-ойрад
гар бичмэл толь бичиг дэх хэлний зарим онцлог**

Нэг. Уг дохионы бичигт ойрад нутгийн аялгууны үгс элбэг тохиолдоно. Монгол хэл, аялгууны хөгжил хувьслыг бусад нутгийн аялгууны жишээ баримт, хэрэглэгдэхүүнтэй харьцуулан судлах нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Тиймээс бидний авч үзэж буй энэхүү төвөд-монгол дохионы бичиг нь монгол үгийг төвөд үсгээр үгчлэн буулгахдаа ойрад аялгууны дуудлагыг баримталж бичсэн байх ба тухайн нутгийн аялгууны үгс нэн элбэг тохиолдож байна. Жишээлбэл:

<u>Төвөд-монгол бар СГГ: Төвөд-ойрад монгол СГГ:</u>	<u>Халх аялгуунд:</u>	
ᠬᠢᠲᠦᠭᠦᠨ	ᠬᠢᠲᠦᠭᠦᠨ (хийтэн)	хүйтэн
ᠥᠨᠴᠢ	ᠥᠨᠴᠢ (өнч)	өмч
ᠵᠠᠰᠠᠬ	ᠵᠠᠰᠠᠬ (ясах)	засах
ᠬᠦᠮᠡᠨ	ᠬᠦᠮᠡᠨ (хүмэн)	хүн
ᠢᠯᠴᠢ	ᠢᠯᠴᠢ ¹ (нилч)	илч
ᠦᠰᠦᠭ	ᠦᠰᠦᠭ (үзүг)	үсэг
ᠵᠠᠰᠠᠮᠠᠯ	ᠵᠠᠰᠠᠮᠠᠯ (ясмал)	засмал
ᠬᠠᠯᠵᠠᠨ	ᠬᠠᠯᠵᠠᠨ (галзан)	халзан
ᠭᠣᠰᠣᠨ	ᠭᠣᠰᠣᠨ (госон)	гутал
ᠭᠦᠷᠢᠯ	ᠭᠦᠷᠢᠯ (гуяр)	гурил
ᠢᠯᠦᠭ	ᠢᠯᠦᠭ (үлүү)	илүү
ᠮᠠᠭᠠᠭᠠᠷ	ᠮᠠᠭᠠᠭᠠᠷ (манагар)	маргааш
ᠲᠠᠭᠠᠨᠠᠢ	ᠲᠠᠭᠠᠨᠠᠢ (тангнай)	тагнай
ᠢᠰᠢᠭᠡᠢ	ᠢᠰᠢᠭᠡᠢ ² (ишгээ)	эсгий

¹ Монгол хэлний их тайлбар тольд “нилчгэнэх” гэж үг халуун илч, уур амьсгал төөнөх гэж тайлбарласан байна.

² Ж.Цолоо (1988) “IŠGÄ” гэж галиглаад эсгий гэжээ. Г.Гантогтох (2011) “heyi” гэж тэмдэглэсэн байдаг. С.Мөнхсайхан (2020) МНТ-ны 202§ “sisgei” (x.1161) хэмээн галиглаад жишээгээр харуулжээ.

ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠬᠠᠢᠰᠤᠨᠢ	тогооны
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨᠠᠨ	засал
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨᠠᠨ	эрүү
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨᠠᠨ	хул (ухаа)шаргал

ГЭХ МЭТ.

Төвөд-ойрад гар бичмэл хувилбараас харахад, “Үгчилсэн дохионы бичиг, дүймэнгийн зүйл нь монгол хэлний нутгийн аялгуу судлах талаар сонин зүйл болохыг тэмдэглэлтэй” (Дорж, 2009: 96) гэсэнчлэн уг гар бичмэл нь монгол хэлний ойрад нутгийн аялгууны үгийн санг судлахад маш сонирхолтой эх хэрэглэгдэхүүн болж өгч байна.

Хоёр. *Уг дохионы бичигт авиа тонгорч³ бичсэн нь бий.* Монгол хэлэнд авиа тонгорох нь нэн элбэг. Авиа зүйд үүнийг авиа, үе тонгорох ёс хэмээнэ. Үг бүтээвэр дэх хоёр авиа харилцан байраа сольсныг авиа тонгорох гэнэ. Авианы тонгорлыг зэрэгцэн ба алгасан тонгорох, эгшиг ба гийгүүлэгч авиа тонгорох гэх мэтээр ангилж болно. Монгол бичгийн хэлний үе, үгийн адагт орж байсан богино эгшгүүд тонгорч, гийгүүлэгчтэйгээ байраа сэлгэсэн нь нэлээд бий. Жишээ нь: *terge(n) > terëg, torγ-a > toröγ, silbe > šilëw* (Санжаа нар, 2008: 197) гэх мэт. Тэгвэл энэхүү тонгорох ёс уг дохионы бичигт ч туссан байдаг. Жишээлбэл:

<i>Төвөд-монгол бар СГГ: Төвөд-ойрад монгол СГГ:</i>	<i>Халх аялгуунд:</i>
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠨ

гэх мэтээр авиа, үе тонгорч тухайн нутгийн аялгууны үгсээр монгол хэл баяжиж байдгийг харж болно.

Гурав. *Төвөд бичгийн уламжлалыг баримтлан хурааж, зүүж бичсэн зүйл нэлээд түгээмэл ажиглагдана.* Жишээ нь:

1. “М” үсгийг хурааж бичсэн нь (ᠮ): *ᠮᠠᠨᠠᠨ* (уншлага), *ᠮᠠᠨᠠᠨ* (тулам), *ᠮᠠᠨᠠᠨ* (хадам), *ᠮᠠᠨᠠᠨ* (чадамгай), *ᠮᠠᠨᠠᠨ* (бардам) гэх мэт.
2. “Р” үсгийг зүүж бичсэн нь (ᠷ): *ᠷᠠᠨᠠᠨ* (эрдэнэ), *ᠷᠠᠨᠠᠨ* (эрэх), *ᠷᠠᠨᠠᠨ* (гэнэтэр), *ᠷᠠᠨᠠᠨ* (тархсан), *ᠷᠠᠨᠠᠨ* (тархи) гэх мэт.

³ Нэг ухагдахууныг нөгөө ухагдахуунтай шүтэлцүүлж, нөгөө ухагдахуунаа түрүүчийн ухагдахуунтай солбиулан хэлэхийг тонгорол гэдэг ба энэхүү тонгорол хэмээхийг монгол хэл шинжлэлд хэд хэдэн янзаар нэрлэсээр ирсэн байна. Үүнд: Д.Ёндон “солбиулал”, Чой.Лувсанжав “өөрчлөл”, Ж.Баянсан “тонгорол”, М.Базаррагчаа “хөрвөл” гэх мэт.

3. “Ш” үсгийг зүүж бичсэн нь (ә): *Ш* (гишгэх) гэх мэт жишээ олон тааралдана.

Энэ мэтээр төвөд бичгийн соёлтой лам нар монгол хэлэнд үгчлэн буулгахдаа зүгээр нэг буулгасангүй монгол хэлнийхээ онцлог, хэв маягт тохируулан төвөд үсгээр үгчлэх зарчмыг хэвшүүлэн тогтоохоор оролдож байсан гэлтэй.

Дөрөв. *Монгол бичгийн хэлний уламжлалыг баримтлан бичсэн нь бий:* Жишээлбэл, ой. *Гурил*, мо. *ᠭᠦᠷᠢᠯ* (гурил), ой. *Цэмбэ*, мо. *ᠴᠡᠮᠪᠡ* (цэмбэ), ой. *Нугас*, мо. *ᠨᠤᠭᠠᠰ* (нугас), ой. *Үзэсгэлэн*, мо. *ᠦᠵᠡᠰᠭᠡᠯᠡᠨ* (үзэсгэлэн), ой. *Бадар*, мо. *ᠪᠠᠳᠠᠷ* (тагнай), ой. *Тавих*, мо. *ᠲᠠᠪᠢᠬ* (тавих), ой. *Айх*, мо. *ᠠᠶᠢᠬ* (айх), ой. *Хаана*, мо. *ᠬᠠᠠᠨᠠ* (хаана), ой. *Нүүр*, мо. *ᠨᠡᠭᠦᠷ* (нүүр) гэх мэт. Үүнээс гадна, монгол бичгийн хэлэнд үгийн эхэнд амьгүй бичдэг уламжлалт үсгийг өөрчилж дуудлагаар нь бичсэн онцлог харагдана. Жишээ нь: мо. *včir* (včir), ой. *o-čir* (o-čir), мо. *tngri* (tngri), ой. *teng-ge-ri* (teng-ge-ri), мо. *blam-a* (blam-a), ой. *la-ma* (la-ma), мо. *gkir* (gkir), ой. *kir* (kir) гэх мэтээр монгол бичгийн хэлээр уламжлалыг баримтлан буулгасан нь сонирхолтой байна.

Тав. *Үг зүй, үсэг зүйн зарим онцлог:* Монгол бичигт гарахын тийн ялгалын *-ača, -eče* хэмээн ялгадаг уг нөхцөлийг дээрх гар бичмэл сударт эр ба эм эгшигт үгэнд аль алинд нь *-eče* (ᠡᠵᠡ) нөхцөл дагуулжээ. Жишээлбэл: *Зуулгаас* (зуулгаас), *Тэндээс* (тэндээс) гэх мэт.

Монгол бичигт үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийг *-bar, -ber*, *-iyar, -iyer* хэмээн ялгаж бичдэгийг ойрад аялгуугаар тэмдэглэсэн уг гар бичмэлд эгшгээр төгссөн үгэнд эр, эм эгшиг үл харгалзан зөвхөн *-ber* (ᠪᠡᠷ) нөхцөл, гийгүүлэгчээр төгссөн үгэнд эр, эм эгшиг үл харгалзан зөвхөн *-iyer* (ᠶᠡᠷ) нөхцөл тус тус дагуулж бичжээ. Жишээлбэл: *Бачтай* (ачаар), *Алгуураар* (алгуураар), *Зарлигаар* (зарлигаар), *Зоригоор* (зоригоор), *Өвсөөр* (нүүдлээр), *Өвсөөр* (өвсөөр) гэх мэт.

Хамтрахын тийн ялгалын нөхцөлийг монгол бичигт *-tai, -tei*-ээр ялгадгийг уг гар бичмэлд эр эгшигт үгэнд *-тай, -той* (ᠲᠠᠢ, ᠲᠡᠢ), эм эгшигт үгэнд *-тэй* (ᠲᠡᠢ) нөхцөл залгасан байна. Жишээ нь: *Бачтай* (бачтай), *Бодтой* (бодтой), *Хөрстэй* (хөрстэй), *Өнгөтэй* (өнгөтэй) гэх мэт.

Энэ мэтээр дохионы бичгийг ойрад аялгуунд тохируулан дохиолохдоо зүгээр ч нэг үгчлэн буулгасангүй ба тод үсгийн дүрмийг тодорхой хэмжээнд баримтлан буулгасан нь илэрхий харагдана.

“Тод номын гэрэл төв”-өөс 2018 онд хэвлэн гаргасан төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл” болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны тасгийн “Монгол номын хөмрөг”-т хадгалагдаж буй А-0975 дугаартай “Ner-e udq-a-yi todudqayči saran-u

gegen gerel kemegdeckь dokiyan-u bičig orusiba” хэмээх хоёр эхийн төвөд үсгээр галигласан зарчмыг харьцуулж үзвэл хэд хэдэн сонирхолтой зүйл ажиглагдаж байна.

Хүснэгт 1.

Эгшгийн харьцуулал

Цагаан толгой	Төвөд үсэг	Жишээ				Кирилл
		Төвөд үсгээр монгол үгийг хадсан байдал				
		Барын хувилбарт		Ойрад хувилбарт		
а	ᠠᠨ	ᠠ	ᠠᠨᠠ	ᠠᠨ	ᠠᠨᠠ	алим
э	ᠡᠨ	ᠡ	ᠡᠨᠡ	ᠡᠨ	ᠡᠨᠡ	эрдэнэ
и	ᠢᠨ	ᠢ	ᠢᠨᠢ	ᠢᠨ	ᠢᠨᠢ	илэрхий
о	ᠣᠨ	ᠣ	ᠣᠨᠣ	ᠣᠨ	ᠣᠨᠣ	ороосон
у	ᠤᠨ	ᠤ	ᠤᠨᠤ	ᠤᠨ	ᠤᠨᠤ	урт
ө	ᠥᠨ	ᠥ	ᠥᠨᠥ	ᠥᠨ	ᠥᠨᠥ	төв
ү	ᠦᠨ	ᠦ	ᠦᠨᠦ	ᠦᠨ	ᠦᠨᠦ	үнэн үг

БАРЫН ЭХ				ОЙРАД МОНГОЛ ГАР БИЧМЭЛ ЭХ			
“У” эгшиг		“Ө” эгшиг		“У” эгшиг		“Ө” эгшиг	
ᠤ	ᠤᠨᠠᠨ	ᠥ	ᠥᠨᠠᠨ	ᠤᠨ	ᠤᠨᠠᠨ	ᠥᠨ	ᠥᠨᠠᠨ
	хусуур		mee		хусуур		mee

Тэгвэл төвөд-ойрад гар бичмэл “Сарны гэгээн гэрэл”-д урагшилсан “æ” эгшиг ба “œ” эгшгийг нарийн тэмдэглэн буулгасныг жишээгээр харуулбал дараах мэт байна. Жишээ нь: æli (æli), æmitʰaŋ (æmitʰaŋ), sœril (sœril), gœβi (gœβi) гэх мэтээр урагшлан урдуур хэлэгдэх байдлыг нарийн тэмдэглэж харуулжээ. Тэгвэл барын эхэд, дээрх байдлыг тусгасан эсэхийг харьцуулж үзэхэд урагшилсан эгшгийг тэгж нарийн тэмдэглээгүй байгааг харж болохоор байна. Жишээ нь:

<i>Төвөд-монгол бар СГГ:</i>	<i>Төвөд-ойрад монгол СГГ:</i>	<i>Халх аялгуунд:</i>
ᠪᠠᠷᠠ	ᠪᠠᠷᠠ	барилах
ᠪᠠᠷᠢ	ᠪᠠᠷᠢ	барих
ᠬᠠᠯᠤᠰ	ᠬᠠᠯᠤᠰ	хальс
ᠰᠠᠷᠢ	ᠰᠠᠷᠢ	сариу гэх мэт.

Хүснэгт 2.

Гийгүүлэгчийн харьцуулал

Цагаан толгой	Төвөд үсэг	Жишээ		
		Төвөд үсгээр монгол үгийг хадсан байдал		Кирилл
		Барын хувилбарт	Ойрад хувилбарт	
н	ᠨ	ᠨᠠᠭ	ᠨᠠᠭ	нөхцөл
нг	ᠨᠭ	ᠨᠭᠠᠨ	ᠨᠭᠠᠨ	сунган
ха, хэ	ᠬᠠ	ᠬᠠᠭ	ᠬᠠᠭ	хөл
га, гэ	ᠭᠠ	ᠭᠠᠨ	ᠭᠠᠨ	гар
д	ᠳᠠ	ᠳᠠᠭ	ᠳᠠᠭ	дотор
т	ᠲᠠ	ᠲᠠᠭ	ᠲᠠᠭ	тэгш
б	ᠪᠠ	ᠪᠠᠭ	ᠪᠠᠭ	бие
м	ᠮᠠ	ᠮᠠᠭ	ᠮᠠᠭ	маш
з, ж	ᠵᠠ	ᠵᠠᠭ	ᠵᠠᠭ	зарлиг
ч, ц	ᠴᠠ	ᠴᠠᠭ	ᠴᠠᠭ	цэрэг
я	ᠶᠠ	ᠶᠠᠭ	ᠶᠠᠭ	явган
р	ᠷᠠ	ᠷᠠᠭ	ᠷᠠᠭ	тавиур
л	ᠯᠠ	ᠯᠠᠭ	ᠯᠠᠭ	лав
с	ᠰᠠ	ᠰᠠᠭ	ᠰᠠᠭ	салгах
ш	ᠱᠠ	ᠱᠠᠭ	ᠱᠠᠭ	шувуу

Барын болон ойрад монгол хувилбарт хэлний хойгуур хэлэгдэх гүн угийн, дуутай хамжих “γ” гийгүүлэгчийг гүн бус угийн, дуутай хамжих “g” гийгүүлэгчээс ялгаж бичсэн байх бөгөөд эдгээрийг тус судруудад харилцан адилгүй тэмдэглэсэн сонирхолтой онцлог харагдаж байна. Жишээлбэл:

БАРЫН ЭХ				ОЙРАД МОНГОЛ ГАР БИЧМЭЛ ЭХ			
Гүн угийн, дуутай хамжих “γ”		гүн бус угийн, дуутай хамжих “g”		Гүн угийн, дуутай хамжих “γ”		гүн бус угийн, дуутай хамжих “g”	
“ ”	ᠭᠦᠨᠠᠭᠠᠨ ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ ᠭᠠᠨ	“ ”	ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ	“ ”	ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ ᠭᠠᠨ	“ ”	ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ ᠭᠡᠨᠠᠭᠡᠨ

Төвөд үсгээр үгчлэх зарчим алгуур аажмаар нарийсан сайжирч байсан боловч, тусгай дүрэм бичиг байгаагүй, гагцхүү уламжлалаар тогтсоор ирсэн учир хөдөлшгүй болсон тийм зарчим бүрмөсөн тогтож чадаагүй байсныг (Пагба, 2009: 227) дээрх хоёр хувилбараас энэ мэтээр илэрхий харж болохоор байна.

Төвөд үсгээр монгол үгийг үгчлэн буулгахдаа төвөд-ойрад гар бичмэл хувилбарт тухайн үгийн үеийн заагт цэг (·) тавьж өгсөн бол барын хэвлэлд цэг (·) тавьсан байхаас гадна холбоо үг байгаа тохиолдолд давхар цэг (··)-ээр тэмдэглэсэн онцлог харагдаж байна. Жишээ нь: бар. *ᠰᠡᠭᠡᠨᠠᠭᠡᠨ* (тогтоол ус), *ᠡᠭᠡᠨᠠᠭᠡᠨ* (эхний утга) гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд, төвөдийн уламжлалт боловсрол төгс эзэмшсэн, монгол бичгийн мэргэд Буддын шашны салбарт үлэмжхэн олон гарч тухайн үеийн эрдэм ухааны бүх чиглэлээр буюу их бага таван ухааныг судлахдаа монгол ахуй нөхцөлд ээнэгшүүлэн боловсруулж (Шагдарсүрэн, 2003: 273) шинэ шинэ баримт сэлтийг нэмэн баяжуулж, нутаг нутгийн онцлогтоо тохируулсаар ирсэн байдгийн нэгэн жишээ болсон “*Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой*” нэрт төвөд-ойрад гар бичмэл хоёр хэлний толь бичиг нь үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгийн сангийн хувьд тухайн үеийн ойрад нутгийн аялгууны онцлогийг буулгахдаа зүгээр ч нэг үгчлэн хуулж буулгасангүй, харин ч тод үсгийн зөв бичих зүй, ойрад нутгийн аялгууны үгсийн дуудлагыг баримталсан зэрэг онцлогууд харагдаж байна.

Барын болон гар бичмэл хувилбарт монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авиаг төвөд үсгийн махбодоор оноосныг харахад, бичигч бүр өөр өөрөөр харилцан адилгүй галигласан байгаа нь төвөд үсгээр галиглах зарчимд нарийн тогтсон дүрэм журам хараахан байсангүй бололтой. Гэвч ингэж төвөд үсгээр монгол үгийг галиглан бичиж ирсэн нь тухайн үеийн бичгийн хэлэнд хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байсан ба монгол

бичгээ сайн мэдэхгүй, төвөд үсэг бичиг мэдэх хүмүүсийн хоорондох бичгийн хэлний үүргийг маш сайн гүйцэтгэсэн нь дамжиггүй.

Ном зүй

“Ner-e udq-a-yi todudqayci saran-u gegen gerel kemegdekъ dokiyan-u biçig orusiba”, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Монгол номын хөмрөг, Дугаар: А-0975, Бээжин бар, 2 мөр, х.62.

Алшаа лхаарамба Агваандандар 2018: Эрхлэн хэвлүүлсэн Б.Мөнхөө, На.Сүхбаатар, Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой. УБ., 2018. 229 тал.

Бадамдорж, Батзаяа 2016: *Бадамдорж Б., Батзаяа Г.* Дөрвөд аялгууны толь. Тод номын гэрэл төв, УБ., 2016. 186 тал.

Батдорж 2019: *Батдорж Ц.* Дөрвөлжин бичгийн тогтолцоо дахь эр, эм гийгүүлэгчийн учир. //Дөрвөлжин үсэг-750 олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2019. -14.

Бүрнээ 2018: *Бүрнээ Д.* Агваандандар бол толь бичгийн уурхай гэж хэлж болох том эрдэмтэн мөн. // Эх хэл бичиг. УБ., 2018. №1 дугаар 21, х.5-7.

Гантогтох 2011: *Гантогтох Г.* Буриад аялгууны толь, УБ., 2011. 780 тал.

Даваасүрэн 2018: *Даваасүрэн Д.* Лхаарамба Агваандандарын найруулсан дохионы хоёр бичгийн тухай. // Эх хэл бичиг, УБ., 2018. №1 дугаар 21, х.11-18.

Дорж 2009: *Дорж Ц.*Төвөд монгол дохионы бичиг, түүвэр нэрсийн тухай (монгол бичгээр). //Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлын эмхэтгэл, I боть, УБ., 2009. х.94.

Ишдорж 1959: *Ишдорж.* Төвөд монгол дохионы бичиг, УБ., 1959. 935 тал.

Лувсанбалдан 1975: *Лувсанбалдан Х.* Тод үсэг, түүний дурсгалууд. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 1975. 356 тал.

Мөнхсайхан 2020: *Мөнхсайхан С.* МНТ-ны үгийг эшлэн үзүүлсэн толь. УБ., 2020. 1522 тал.

Отгонбаатар, Цендина 2014: *Отгонбаатар Р., Цендина А.Д.* Монгол үсэг бичгийн дээж. М., 2014. 221 тал.

Пагба 2009: *Пагба Т.* Төвөд үсгээр үгчилсэн монгол ном зохиол.//Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлын эмхэтгэл, I боть, УБ., 2009. х.218-229.

Самбуудорж 2002: *Самбуудорж О.* Монгол хэлний ойрад аялгууны фонемын тогтолцоо. – ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2002. 175 тал.

Толь бичиг судлалын асуудалд 2008: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, УБ., 2008.235 тал.

Төмөртоогоо 2018: *Төмөртоогоо Д.* Агваандандар лхаарамбын хэл шинжлэлийн бүтээл.// Эх хэл бичиг, УБ., 2018. №1 дугаар 21, х.8-10.

- Түвшинтөгс 2008: *Түвшинтөгс Б.* Монгол, манж хоёр хэлний толь бичгийн тухай.// Толь бичиг судлалын асуудал, ШУА, Хэл зохиолын хүрээлэн. УБ., 2008. х.113-133.
- Чулуунбаатар 2002: *Чулуунбаатар Л.* Нүүдэлчин монголчуудын үсэг бичгийн соёл. УБ., 2002. 251 тал.
- Шагдарсүрэн 2003: *Шагдарсүрэн Ц.* Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 2003. 304 тал.
- Шагдарсүрэн 2001: *Шагдарсүрэн Ц.* Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ., 2001. 300 тал.

DOI 10.48612/IVRRAN/gzkv-z6pr-gex4

Бикмаева К.И.

**НАЦИОНАЛЬНЫЕ ПРОГРАММЫ ПО МОНГОЛЬСКОЙ
ПИСЬМЕННОСТИ (МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР)
КАК ОДИН ИЗ ОСНОВНЫХ ДОКУМЕНТОВ В ОБЛАСТИ
ЯЗЫКОВОЙ ПОЛИТИКИ МОНГОЛИИ**

Исторически языковая политика была важной частью культурной политики Монголии. В XX веке по данному направлению произошло несколько существенных реформ, которые оказали большое влияние на монгольское общество. После Демократической революции Монголию затронули сильные изменения во всех сферах, в том числе и языковой. В какой-то степени мы говорим о том, что начался процесс возвращения своей национальной идентичности, важнейшей частью которой была монгольская письменность. В статье рассматриваются Национальные программы по монгольской письменности – основные документы, регламентирующие политику в данном направлении. Но за более чем 20 лет, с момента принятия программы позиционирование монгольской письменности в обществе сильно изменилось. И на данный момент можно говорить об использовании двух равнозначных систем письменности: кириллицы и традиционной монгольской графики.

Ключевые слова: языковая политика, монгольский язык, монгольская национальная письменность, кириллица.

Bikmaeva Karina I.

**NATIONAL PROGRAMS ON MONGOLIAN SCRIPT
(МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР)
AS THE MAIN DOCUMENT IN THE FIELD OF MONGOLIAN SCRIPT**

Historically, language policy has been an essential part of the cultural policy of Mongolia. In the 20th century there were several significant reforms, which had a great impact on Mongolian society. After the Democratic Revolution, Mongolia was affected by strong changes in all areas, including language. To some extent, we are talking about the process of returning their national identity has begun and the most important part of it was the Mongolian script. The article discusses the National Programs on the Mongolian script - the main documents regulating the policy in this field. For more than 20 years, since the introduction of the

program, the understanding and estimating of the Mongolian script in society has changed a lot. And at the moment we talk about the use of two equivalent writing systems: Cyrillic and traditional Mongolian script.

Key words: language policy, Mongolian language, Mongolian national script, Cyrillic alphabet.

Язык существует как в устной, так и в письменной форме. Именно благодаря письменности мы передаем речевую информацию на расстоянии и закрепляем ее во времени. Хотя письменный вариант языка возник много позже, чем устный, но он стал в большинстве обществ не менее важен [Алпатов 2018. С. 9].

Вопросы языковой политики были актуальны для Монголии всегда. Со времен Хубилай-хана они касались в основном сферы письменности [Mayagmar 2021. Р. 74]. Как известно, на протяжении веков в Монголии существовало достаточно большое количество разнообразных письменностей. Процессы унификации и реформирования письма происходили и в средние века, и в XX в., продолжают они и в нынешнем столетии.

Основной письменностью монголов является традиционное монгольское письмо, самый ранний памятник которого датируется XIII в. Затем, на протяжении столетий происходили разные реформы письменности, которые были нацелены на создание новой письменности, однако монгольская письменность сохранилась до наших дней и по-прежнему представляет собой национальный символ Монголии [Arai 2006. Р. 311].

Большим вызовом для монголов стало использование кириллицы в XX в., поскольку это означало отрыв от традиции. И в какой-то степени могло стать причиной потери национальной идентичности, которая выражалась через традиционную монгольскую письменность.

Социально-политические реформы, начатые в 1990-х гг., стали основой для возрождения национальной монгольской письменности. Только в 1990 г. были приняты следующие важные документы: одно постановление Совета министров МНР и шесть приказов министра народного образования МНР, что стало важным шагом восстановления и развития монгольской письменности на уровне государственной политики [Дэмбэрэл 2021. С. 111].

На данный момент национальную монгольскую письменность можно рассматривать в рамках:

- Общего процесса восстановления историко-культурных ценностей;
- Реформирования структуры и грамматики монгольского языка;
- Создания единого национального символа.

Цель данного исследования - изучить «Национальные программы по монгольской письменности», которые являются основным документом, регламентирующим языковую политику в области традиционной монгольской письменности. Для этого мы поставили следующие задачи: разобрать, проанализировать и сравнить три программы, которые выходили в 1995, 2008 и 2020 гг. соответственно. Таким образом, источниковой базой исследования стали непосредственно «Национальные программы по монгольской письменности-I, II, III» и сопутствующие документы на монгольском языке.

Как уже упоминалось выше, основным толчком к возрождению монгольской письменности стало демократическое движение середины 90-х годов. В 1991 г. было выпущено постановление № 36 Малого государственного хурала «О подготовке работы по переходу к обеспечению ведения всей официальной документации МДП на монгольской письменности» [Дырхеева 2019. С. 100].

Главным нормативным актом, регулирующим языковую политику в целом является Закон о монгольском языке 1995 г. В законе было впервые прописано то, что монгольская национальная письменность является официальной письменностью Монголии, наравне с кириллицей. Однако основными документами, определяющими и корректирующими политику в сфере письменностей, являются, как уже говорилось выше, Национальные программы по монгольской письменности (далее - НПМП). Впервые такая программа была принята в 1995 г. сроком на 10 лет. Основной целью стало распространение монгольской письменности и ее повсеместное внедрение [Монгол бичгийн – I 1995]. Результаты программы признали неудовлетворительными, и в 2008 году была более подробно и структурно составлена НПМП II.

К основным целям и задачам данной программы относятся: овладение монголами монгольской письменности, которая является неоспоримым и неповторим вкладом в мировую культуру и наследием монголов; предотвращение возможности забвения письменности в будущем, повышение уровня преподавания, изучение

и исследование монгольской письменности, перевод письма на уровень общеупотребительного.

Для реализации этой цели были поставлены следующие задачи:

- Подготовка и переподготовка учителей и преподавателей монгольской письменности;
- Улучшение среды для изучения монгольской письменности и расширение сферы ее употребления;
- Расширение работы по научному исследованию монгольской письменности.

В рамках программы осуществлялись следующие мероприятия:

1. Поскольку важнейшей задачей становилось распространение монгольской письменности, большое внимание уделялось учебным заведениям, в которых она преподавалась. В первую очередь, отмечалась необходимость проведения переподготовки педагогов по монгольскому языку и повышения их квалификации. Также рассматривалась возможность изменения и доработки образовательных программ, как в школах, так и в высших учебных заведениях. Что касается вузов, то отмечалась возможность изучения национальной монгольской письменности в качестве дополнительной учебной дисциплины. Также выдвигалась инициатива по введению экзамена на знание национальной монгольской письменности для поступающих на программы подготовки по гуманитарным специальностям.

2. Важным шагом к популяризации письменности стало бы расширение среды ее использования. Для этого было введено требование дублировать все документы, в первую очередь государственные, на монгольскую письменность. Это придавало ей легитимный статус. Кроме того, поддерживалось использование письменности для маркировки продуктов, указания адресов организаций, сельскохозяйственных объединений и государственных учреждений.

3. Отдельной областью, требовавшей доработки, стала печатная продукция. Необходимо было подготовить к печати учебники, рабочие тетради, методические пособия и учебные принадлежности для использования на занятиях по монгольской письменности. Также отмечалось, что на компьютеры, используемые в учебных заведениях, стоит установить и программы с монгольским алфавитом.

4. Разумеется, кроме всего прочего оказывалась поддержка и научной деятельности. Предполагалось повышение издательской

активности в области публикации ранних сочинений, написанных традиционным монгольским письмом, а также перевод современных монгольских произведений на национальную письменность.

5. Предполагалось и другими доступными мерами способствовать популяризации монгольского языка [Монгол бичгийн – II 2008].

Программа принималась на срок до 2015 г. Стоит отметить, что многие пункты и мероприятия, указанные в программе 2008 г. имели рекомендательный характер, намечались лишь общие цели. Основным направлением была попытка повысить интерес населения, в первую очередь, молодежи, к монгольской письменности.

Следующая программа по монгольской письменности была принята в марте 2020 г. В определенной степени она представляет собой более четко структурированный нормативный акт с прописанными целями и задачами. Изменения в характере новой программы произошли после принятия Закона о монгольском языке в 2015 г. [Монгол хэлний тухай 2015]. Особое внимание в новом законе обращает на себя пункт 7, в соответствии с которым с 1 января 2025 г. все государственные организации обязаны вести свою печатную деятельность на двух шрифтах: на монгольской кириллице и на монгольской письменности. Поэтому новая национальная программа по монгольской письменности, срок реализации которой рассчитан на четыре года – с 2020 по 2024 - нацелена на обеспечение плавного перехода на монгольскую письменность и создание среды для ее применения. В рамках программы планируется:

1. Создать единый электронный портал на монгольской национальной письменности, подготовить электронные учебники, словари, а также обучающие программы. Отдельно отмечена необходимость использовать национальную монгольскую письменность в социальных сетях и создавать соответствующий контент.

2. Увеличить число печатного материала на монгольской письменности. Способствовать переизданию исторических памятников на монгольской письменности.

3. В программе многое говорится об издании газет и журналов на монгольской письменности. Так, было утверждено, что с 2021 г. журнал «Государственные новости» будет выходить на кириллице и монгольской письменности, а с 2023 г. исключительно на монгольской письменности. Более того, подчеркивается, что число печатных газет,

журналов, новостных изданий, выходящих на двух письменностях - классической и кириллице - должно быть не меньше 30% от общего числа.

4. Отмечалось, что необходимо ввести дублирование написания названий и адресов государственных, общественных и частных организаций, улиц, дорожных знаков, этикеток, состава товаров на монгольской письменности.

5. В образовательной сфере планируется введение в общеобразовательных школах обязательного выпускного экзамена по монгольскому языку, куда будет включена монгольская письменность, процент вопросов по которой от общего содержания должен быть не меньше 30. С 2020-2021 учебного года монгольская письменность стала обязательным предметом во всех вузах, колледжах, профессиональных учебно-производственных центрах. Также в качестве популяризации изучения письменности среди школьников предлагалось проводить ежегодные олимпиады по монгольской письменности, начиная с 2021 г.

6. Большое внимание в программе, разумеется, уделяется и преподавательскому составу. Отмечается необходимость оказания поддержки, в том числе и материальной, как школьным, так и частным преподавателям монгольской письменности, а также проводить мероприятия по повышению квалификации педагогов.

7. Также подчеркивалась важность проведения обучающих семинаров и для работников государственных ведомств, в том числе в дипломатических представительствах Монголии за рубежом, монгольских граждан и их детей, проживающих или работающих за границей [Монгол бичгийн – III 2020].

Основные положения НППП-III демонстрируют, что круг задач сильно расширился, а национальная монгольская письменность заняла основное место в повестке языковой политики Монголии. В 2020 г. была поставлена задача не просто популяризировать монгольскую письменность, а уже полноценно внедрять и использовать ее в образовании, вести на ней документооборот. Фактически третья программа официально утвердила монгольскую письменность как вторую графическую систему в Монголии. И именно из-за этого большое внимание уделяется не просто изучению старого письма, а использованию его на вывесках, наименовании товаров, обложках книг.

В целом же можно сказать, что II и III программы отвечают разным целям. НПМП-II была преимущественно направлена на сохранение культурно-исторической ценности национальной монгольской письменности, расширение ее изучения и поиск путей применения. Последняя же программа определяет те сферы, где монгольская письменность должна применяться, а благодаря цифровизации учебно-методических курсов, созданию словарей и обучающих программ, делает письмо более доступным и понятным. Такая эволюция представляется логичной, поскольку соответствует общей тенденции языковой политики Монголии последних лет, в которой использование двух письменностей на равнозначной основе видится как одна из основных целей. Кроме того, популяризация, как письменности, так и монгольского языка играет важную роль в укреплении национальной идентичности.

Однако, стоит сказать, что принятые программы, а особенно последняя, по-прежнему вызывают большую дискуссию в обществе. Согласно принятой новой программе национальной письменности, к 2025 г. подавляющее большинство населения должно уметь читать и писать на монгольской письменности. Однако существует несколько проблем на пути к достижению данной цели:

1. В официальном документе программы не указан уровень, который должен быть достигнут к моменту окончания реализации данной программы. Отмечалось, что студенты всех вузов будут в обязательном порядке изучать монгольскую письменность. Однако нет пояснения, какого уровня должны достичь студенты в изучении письменности, с каким уровнем образуются группы, поскольку из-за длительного проведения данной программы, некоторые студенты могут обладать базовыми навыками монгольской письменности. Также непонятно, с какими начальными знаниями будут приходить студенты.

2. Отсутствие среды для применения монгольского письма. Помимо неопределенности уровня необходимых знаний, непонятно, где, как и зачем монгольская письменность собственно будет применяться. Школьники и студенты (отдельных направлений) изучают письменность уже порядка 25 лет. Однако она часто забывается, потому что полученные знания нигде применить.

3. Важно также, чтобы изучение монгольской письменности не шло в ущерб другим предметам и языкам. Иначе в итоге может оказаться, что результаты и в монгольской письменности, и в

английском, например, будут весьма слабыми. Согласно новой программе общеобразовательных школ, с 6 по 12 класс в неделю будет два урока монгольской национальной письменности. И это можно считать действительно достаточно интенсивным курсом. Однако по-прежнему нет ответа, для чего, в какой среде будет использоваться письменность.

В целом же, хотелось бы еще раз отметить, что начиная с 1991 г., языковая политика Монголии преимущественно направлена на восстановление национальной письменности, расширение возможностей ее употребления и широкое внедрение в жизнь общества. Старт этой политики отражен в первых документах на уровне Министерства образования, принятых в период социально-политических реформ в монгольском обществе, когда в учебных учреждениях началась работа по составлению пособий и подбору кадров для преподавания монгольской письменности [Дэмбэрэл 2020. С. 115]. Эта деятельность, с одной стороны, направлена на сохранение уникальной истории и культуры монголов, их аутентичного письма. Но в то же время присутствует и политический фактор. История развития письменности в разных обществах показывает, что письмо практически с самого его появления было орудием власти и, соответственно, его форма, сферы функционирования, доступ к нему широких масс населения фактически постоянно находились под пристальным вниманием власть предержащих. Общеизвестно также, что проблема графического оформления тесно связана не только с политической ориентацией носителей языка, но и с культурно-религиозной [Дырхеева 2019. С. 99]. Мы можем сказать, что сейчас возрождение национального монгольского письма – это в какой-то степени поиск национальной идентичности, возвращение к национальной культуре, после длительного периода советизации, а также возможность подчеркнуть уникальность монгольского наследия, что особенно важно, принимая во внимание внешнеполитические вызовы.

Использованная литература

- Алпатов 2018: *Алпатов В.М.* Языкознание: от Аристотеля до компьютерной лингвистики. М: Альпина нон-фикшн, 2018.
- Дэмбэрэл 2021: *Дэмбэрэл Колягийн.* Государственная политика Монголии по отношению к монгольской письменности // Монголоведение. 2021. Т. 13 №1. С. 108-119.

- Дырхеева, Наранчимэг 2019: *Дырхеева Г.А., Наранчимэг Гомбодоржийн. Языковая политика Монголии: проблема возрождения старомонгольской письменности (монгольская письменность) // Гуманитарный вектор. 2019. Т. 14, №3. С. 98-103.*
- Монгол бичгийн – I 1995: Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг батлах тухай (= Об утверждении национальной программы монгольской письменности) [электронный ресурс] // Улсын Их Хурлын тогтоол (Постановление Великого государственного хурала). 23.06.1995.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Интегрированная правовая информационная система) URL: <https://old.legalinfo.mn/annex/details/3283?lawid=6353> (Дата обращения: 24.10.2022).
- Монгол бичгийн – II 2008: Монгол бичгийн үндэсний хөтөлбөр – II (2020 оны 96 дугаар тогтоолоор хүчингүй болсон) (Национальная программа монгольской письменности – II (отменена постановлением правительства № 96 от 2020 г.) [электронный ресурс] // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/2390?lawid=7833> (Дата обращения: 19.03.2021).
- Монгол бичгийн – III 2020: Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэлэлцэн баталлаа (Утверждена национальная программа монгольской письменности - III) [электронный ресурс] //Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (= Национальная аккредитация образования). 18.03.2020. URL: <https://legalinfo.mn/mn/detail/15248> (Дата обращения: 19.03.2021).
- Монгол хэлний тухай 2015: Монгол хэлний тухай (= О монгольском языке) [электронный ресурс] // Монгол улсын хууль (= Закон Монголии). 12.02.2015. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (= Интегрированная правовая информационная система). URL: <https://legalinfo.mn/mn/detail/10932> (Дата обращения: 15.04.2021).
- Arai 2006: *Arai, Yukiyasu. "Integration and Separation of 'language': Language Policies of Mongolian Peoples in the USSR and Mongolia, 1920-1940 [indicates How Policies Integrate and Divide Languages Through the Example of the Buryats, Kalmyks and Mongols, Who Adopted Different Alphabets]."* Reconstruction and interaction of Slavic Eurasia and its neighboring worlds. Ed. Osamu Ieda and Tomohiko Uyama. Slavic Research Center, Hokkaido University, 2006, 309-334 p.
- Mayagmar 2021: *Mayagmar S. Official Script Changes in Socialist Mongolia. Socialist and Post-Socialist Mongolia: Nation, Identity, and Culture. Edited by Simon Wickhamsmith, Phillip P. Marzluf. Routledge, 2021, 282 p.*

DOI10.48612/IVRRAN/xbdh-ne7u-bae7

Ганбат

ИБН АРАБШАХ-ИЙН “ACÂIBU’L MAKDÛR” ЗОХИОЛД НҮҮДЭЛЧДИЙН БАЙЛДАХ АРГА, БОДЛОГЫН ТУХАЙД ӨГҮҮЛСЭН НЬ

Төв Азийн байлдан дагуулагч Эмир Төмөрийн эрин үед (НТ 1336-1405 он) амьдарч байсан түүхч Ибн Арабшах байлдан дагуулагчийн талаар “Acaibu’l makdûr fi nevâib-i Timur” буюу “Наиб Төмөрийн гайхамшигт хувь тавилан” алдарт зохиол туурвижээ. Тэрээр 62 настайдаа, НТ 1450 онд (Хижрийн 854 он) Каир хотод таалал төгссөн хэдий ч зохиол бүтээл нь түүнийг түүхнээ мөнхлөн үлдээсэн билээ. Ибн Арабшах “Наиб Төмөрийн гайхамшигт хувь тавилан” зохиолдоо Цагадайн монголчууд болон эмир Төмөрийн цэргийн бодлого, арга барилын талаар дэлгэрэнгүй дурдсанаас энэхүү илтгэлд нүүдэлчдийн (монгол) цэргийн арга бодлогын тухайд өгүүлснийг авч үзэв.

Түлхүүр үгс: Ибн Арабшах, эмир Төмөр, Цагаадайн монголчууд, эмир Төмөрийн цэрэг, Самарканд 

L.Ganbat

THE NOMADIC MILITARY TACTICS AND STRATEGICS WRITTEN ABOUT IN IBN ARABSHAH’S “ACÂIBU’L MAKDÛR”

Ibn Arabshah was a famous historianduring the Age of Emir Timur (1336-1405 AD), the great conqueror of Central Asia. He wrote the famous novel “Acaibu’l makdûr fi nevâib-i Timur” or “The Miraculous Fate of Naib Timur” about the conqueror. While he died in Cairo in 854 AH (1450AD) at the age of 62, but his works were able to immortalize his name forever in history. Ibn Arabshah’s writings contain detailed information about the Mongols under Chagadai Khan and the military policies and methods of Emir Timur. For the purposes of this paper, we have aimed to determine how such military policies and methods, as reflected in “The Miraculous Fate of Naib Timur”, corrected with the military policies and methods of the (Mongol) nomads.

Key words: Ibn Arabshah, emir Timor, Chagadai Mongols, armies of amir Timur, Samarkand

Сурвалжийн тухай

Дундад Азийн түүхийн талаар бичигдсэн арабын түүхчдийн дотор Ибн Арабшах ихээхэн нэр хүндтэй. Ибн Арабшах бээр 1388 онд Дамаскт мэндэлсэн бөгөөд Дундад Азийн улс түмэн, хотуудын талаар нэвтэрхий мэддэг эрдэмт хүмүүн байжээ. Тэрээр өөрийн цаг үеийн хамгийн хүчирхэг байлдан дагуулагч эмир Төмөр (НТ. 1336-1405 он)-ийн талаар *“Acaibu’l makdûr fi nevâib-i Timur”* буюу *“Найб Төмөрийн гайхамшигт хувь тавилан”* хэмээх алдарт зохиолыг туурвин түүхэнд нэрээ мөнхөлсөн билээ. Ибн Арабшах бээр Хижрийн 854 (НТ. 1450) онд 62 насандаа Каир хотноо нас барсан юм.

Түүний бичсэн *“Acaibu’l makdûr fi nevâib-i Timur”* буюу *“Найб Төмөрийн гайхамшигт хувь тавилан”* зохиол нь эмир Төмөрийн аян дайн түүх, Дундад Азийн ард түмнүүдийн түүхийн талаар тодорхой өгүүлсэн зохиол бөгөөд 1435 оны орчим бичиж төгсгөсөн болов уу гэж таамагладаг. Тус зохиолын 1448-1449, 1446-1447 онд бичигдсэн хоёр хувилбар эх БНТУ-ын III Ахмедийн номын санд хадгалагдаж байна. Үүнээс гадна Сири улсад мөн хэд хэдэн хувилбар эх бий. Зохиол нь франц /1658/, латин /1772/, англи /1936/, перс /1960/ хэлээр орчуулагдаж, 1979 онд Каир, 1986 онд Бейрутад араб хэлээр, 1992 онд Ташкент хотноо узбек хэлээр тус тус орчуулагдан хэвлэгдэж байжээ.

Уг зохиолд Цагадайн монголчууд, эмир Төмөрийн үеийн Дундад Азийн улс түмнүүдийн амьдрал, нийгэм, соёл зэрэг өргөн хүрээний асуудлыг хамран авч үзсэн байна. Зохиолын онцлог тал нь Низам уд-дин Шами, Шереф уд-дин нар бүтээлдээ Эмир Төмөрийн амьдрал, үйл хэргийг магтан өгүүлдэг [Nizameddin-i Şvmi 1949] бол, уг зохиол эсрэгээрээ түүний үүтгэсэн “гай зовлон”-гийн талаар дэлгэрэнгүй дурддаг. Чингэхдээ Төмөрийг “өөдгүй”, “хазгар” гэх мэт доромж нэрээр нь бичиж тэмдэглэсэн. Үүний шалтгаан нь уг зохиолын зохиогч Ибн Арабшах бээр Төмөрийн Сири нутагт явуулсан аян дайны үед Дамаск хотыг эзлэх үед 12 настайдаа олзлогдон Самарканд руу хүргэгдсэн хувь заяанаас нь үүдсэн хэрэг болов уу. Иймээс ибн Арабшах бээр Төмөрийн эсрэг байлдсан, түүний эсрэг хандсан хүмүүсийг магтан бичих явдлыг зохиолдоо дэлгэрэнгүй дурдсан. Үүний нөгөө талд ибн Арабшах гэгч “золгүйгээр олзлогдсон хөвгүүн”-ий хувь тавилан Эмир Төмөрийн үйл хэрэгтэй огтлолцсоны үрээр тухайн үеийн соёл, шинжлэх ухааны төв Самарканд хотноо эрдэм боловсрол эзэмшин нэрт эрдэмтэн болох замнал болон хувирсан билээ.

Ибн Арабшахийн туурвисан эл зохиолыг нь өргөн агуулгаар нь авч үзвэл, Цагадайн улсын “Сэргэн мандал” гэгдэх Төмөрийн улсын түүхийн тухай мэт боловч Дундад Азийн ард түмнүүдийн нийгмийн талаар тодорхой дүрслэн бичсэн, нөгөө талаар Төмөрийн улсын цэргийн талаар цөөнгүй зүйлийг тэмдэглэсэн зэрэг нь Төв Азийн нүүдэлчдийн цэргийн түүхийг тодруулан гаргах чухал нэгэн баримт сурвалж болохыг илтгэн харуулж байна. Эмир Төмөрийн улсын цэрэг дайны уламжлал нь Цагадайн монголчуудаас шууд өвлөгдсөн бөгөөд энэ нь Монголын эзэнт гүрний монголчуудаас уг эхтэй нь тодорхой. Нөгөө талаар энэ нь тал нутгийн нүүдэлчдийн дайтах арга ухаан, бодлоготой салшгүй холбоотой билээ.

Эмир Төмөр нь Цагадайн монголчуудыг нэгтгэн авсна дараа цэргийн зохион байгуулалтыг аравтын тогтолцоог хэрэгжүүлж 100, 1000, 10,000 цэргийн захирагч нарыг томилсон [Kafalı 1974. s.339]. Тиймээс ибн Арабшахийн зохиолд гарч буй цэргийн холбогдол бүхий мэдээ баримт нь эмир Төмөрийн улсын түүхэнд хамаарах зүйл мэт боловч нөгөө талаар нүүдэлчдийн цэрэг дайны түүхийг тодруулан гаргахад чухал ач холбогдолтой.

Нүүдэлчдийн дайны урлагт тагнан турших, байлдах, дайныг төгсгөх хүртэл хэд хэдэн чухал үе шаттай. Хэдийгээр хүн төрөлхтөний хувьд амьдралын хэв маягаас хамаараад суурин хийгээд нүүдлийн ертөнцөд хуваагдсан боловч цэрэг дайны арга, бодлого зүйлүүдэд ижил зүйлүүд олон. Гэхдээ ялгаатай талууд ч бас цөөнгүй. Ийм учраас нүүдэлчдийн байлдах арга, бодлого ч суурин иргэдийнхээс өөр байсан гэж үздэг. Үүнийг ибн Арабшахийн зохиолд дараах байдлаар дурдсан байдгаас дараах зүйлүүдийг тоймлон авч үзэж болох юм.

Ав хомрог:

Их цэргийг дайнд байлдаанд дасган сургах нэг арга бол ав хомрог билээ. Монголчуудын ав хомрогын талаар Жувейни-гийн бичсэн “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх”-нд тодорхой өгүүлдэг. Харин Дундад Азийн түүхэнд Монголын эзэнт гүрний монголчуудын дараа энэ уламжлалыг Төмөрийн цэрэгт мөн хэрэгжүүлсэн байдаг.

Ибн Арабшах ав хомрогын талаар: *Төмөр нэгэн удаа авд мордов. Занишил ёсоор цэргийн зарим хэсгийг баруун тийш, нөгөө хэсгийг зүүн тийш, явган цэргийг төв хэсэгт, морьт цэргийг тосгод руу, үлдсэн цэргээ уулын орой, нуруудыг бүслэхийг зарлиг болов. Тэдний үүрэг нь ан амьтдыг агнах бус чанга дуугаар хашихирч, тэдгээр амьтдыг үхэл рүү нь туух авчрах явдал юм. Бүгд өөр өөрийн үүргийг ягштал биелүүлнэ.*

Цэргүүд чангаар хашихиралдан бүслэлтээ хумихад амьтад хүнгүй хэсэг рүү зугтан үргэх ажээ. Үнэн хэрэгтээ зугтах газаргүй бөгөөд нэгэнт тэдгээрийг бүслэн явах замыг хаасан билээ. Зүг зүг тийш зугтахаар ийш тийш давхилдах боловч аажмаар тэдгээр амьтад тайвширч нэгэн газарт хуран зогсоно. Энэ үед Төмөр хэнгэрэг дэлдэж, бүрээ үлээхийг зарлигласанд эргэн тойронд их дуу чимээ гарч бүх амьтад айн чичрэн зогсох ажгуу. Тэд бие биендээ ойртон зогсож “ертөнцийн төгсгөл” ирэв гэлцэх, ... энэ үед Төмөр, хөвгүүд, ач нарын хамтаар довтлон орж нум сум харваж, жад шидэж ав хомрогыг эхлүүлнэ” [İbni Arabşah 2012.s.441] гэжээ. Энэ мэдээ нь их цэргийг дайнд тулалдаанд дадлага, туршлагатай болгон сургахад ав хомрого нь ихээхэн чухал үүрэгтэй байсныг харуулж буй хэрэг болно. Дээрх мэдээ нь Монголын эзэнт гүрний түүхийн нэгэн чухал сурвалжуудын нэгэн Ала ад-дин Ата Мелик Жувейнигийн 1260 онд туурвисан “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх” зохиол дахь монголчуудын ав хомрогын талаарх өгүүлэмжтэй ижил байгаа нь цэрэг, дайчдыг сурган бэлтгэх үндсэн арга нь ав хомрог хэвээр байсныг харуулж буй хэрэг юм [Alaaeddin Ata Melik Cüveyno 1999].

Тагнуул:

Нүүдэлчдийн байлдах арга, бодлогод хоёр тал байлдахаас өмнө тагнуул туршуулын үйл ажиллагааг идэвхитэй явуулдаг байсан талаар түүхийн сурвалжуудад тэмдэглэл цөөнгүй. Төмөрийн цэргийн тагнуулын талаар ибн Арабшах дараах баримтуудыг дурдсан байна. “Бүх л газарт мэдээлэгч илгээн, үлдсэн нутгуудад тагнуул суулгадаг. Тухайлбал түүний туслагч нарын нэг, тагнуулуудаас Эмир Атламиш [Аталмиш], нөгөө нь ядуу хүний дүрээр хэрэн явах ба Төмөрийн зөвлөлийн хүндэт хүн Месут ал-Күхжани нар болно. Нэг нь Каирт сурвалжит хүний дүрээр байхад, нөгөө нь Дамаскийн Семисатийн медресе-д нэгэн суфигийн дүрээр байдаг. Төмөрийн тагнуул нар нь энгийн нэгэн үүргийн наймаачин, баян худалдаачин, бүдүүлэг бөх, үймээн үүсгэгч, зовлонт хүн, дархан, од эрхэс шинжигч, хэрмэл, цайлган ам султай нэгэн, хэрэн явах дервиш, далайчин, хүрз зарагч, аялагч, дөлгөөн зант ус зардаг хүн, хөгжилтэй яриатай гуталчин, ховч хөгшин эмгэн, эрдэм номд шамдаж дорноос баруун зүгт хүн эмчлэх аргад суралцаж буй хүний дүрээр явна” [İbni Arabşah 2012. s.432]. Энэ мэтээр тэд “очсон улсынхаа зам харилцаа, газар орны байдал зэрэг мэдээллийг цаасан дээр зурах ба хотууд хийгээд тэдгээрийн хоорон дахь зайг тэмдэглэнэ. Мөн улсынхаа хаана байдаг, хот, тосгодын нэр, оршин суух ард түмнүүд, хэний захиргаанд байдаг” [İbni Arabşah 2012. s.433]

зэргийг илтгэн бичдэг байсан ажээ. Мөн “Төмөр зэргэлдээх улсынхаа хил орчмын талаар мэдээллийг 1000 хүнтэй хөнгөн отрядуудын хүчээр цуглуулж байв. Усгүй, говь тал нутагт тэмээ унаж, бусад газар оронд мориор, заримдаа явган явна” [М.И.Иванин 2013. s.143]. Ийнхүү өргөн хүрээг хамруулсан цэрэг дайны мэдээлэл цуглуулах нь ирээдүйн байлдааны ажиллагааг амжилттай болгох боломж, давуу талыг эмир Төмөрийн цэрэгт олгож байв. Монголын эзэнт гүрний түүхэнд цэргийн тагнуул чухал үүрэгтэй байсан тэрхүү уламжлалыг XIV зууны Дундад Азийн цэрэг дайны урлагт эмир Төмөр амжилттайгаар хэрэгжүүлж чадсан гэж үзэж болно.

Байлдах арга:

Нүүдэлчдийн байлдах аргын дотор нэг чухал нь дайсныг хууран мэхлэх явдал байдаг. Дайсныг хуурч аргандаа оруулах нь байлдааны ажиллагааг амжилттай явуулах нэгэн үндэс байв. Эмир Хуссейн хийгээд Төмөрийн цэрэг тулалдах үед “Хоёр талын хувцас, зэвсэг адил тул Эмир Хуссейны цэргийн хажуугаар өнгөрсөнд тэд өөрсдийн тал хэмээн санаж үл тоов. (Төмөрийн) цэргүүд хэсэг зуур амарсны дараагаар дайсныг гэнэт довтлон хүчтэй дайралт хийв” [İbni Arabşah 2012. s.46] гэдэг. Энэ тулалдаан эмир Төмөрийн талд ашигтайгаар эргэх нөхцөл болжээ. Мөн өөр нэгэн тулалдаанд “Төмөрийн 1,000 орчим хүнтэй манлай ирсэнд Султаны цэргийн 100 хүн угтан байлдсанд тэд ялагдан ухран зугтав” [İbni Arabşah 2012. s.237] гэдэг. Энэ бол байлдааны хууран мэхлэх заль хэрэглэсэн тод жишээ болно.

Ийнхүү хуурч мэхлэх нь дайтаж буй талынханд ашигтай болж хувирах тохиолдол ч байв. Тухайлбал, Шах Мансуртай байлдсанд: *Ирак-и Ажемд. “(Шөнөөр) Энэ үед шейх Мансурт нэгэн зальт санаа төрөв. Адууны дотроос нэгэн гүүг сонгон дөчин зэс сав сүүлэнд бат бөх уяад түүнийг дайсны хүрээ рүү хөөж орхив. Гүү дайсны хүрээн дотор давхин үймээн гаргасанд тэд дайсан ирлээ хэмээн илдээ сугалан хэн хэнийгээ үл мэдэн хоорондоо цавчилдав. Энэ үед шейх Мансур тэднийг авын хойноос хөөх гэж буй харцага мэт харж суулаа. Өгүүлэх нь бие биенээ хөнөөсөөр 10,000 хүн үрэгдэв. Шөнө өөрсдийн майхныг нураан өглөө болох үед өөрсдийн тугаа хараад ямар гай тохиолдсоныг ойлгов. Тэрхүү хараалт шөнө үл дууссан ч болоосой!”* [İbni Arabşah 2012. s.82-83] гэдэг. Энэ сургамжит үйл явдал эмир Төмөр өөрийн цэрэгт дүрэмт хувцастай болох нэг шалтгаан болсон байж болох юм.

Тал нутгийн нүүдэлчдийн түүхэнд дайсныг хууран мэхэлсэн тухайд олон арга байдаг талаар дурдахдаа “галаар мэхлэх” арга хэрэглэсэн

талаар хэд хэдэн тэмдэглэл байдаг. Цэргийн тоог нэмэгдүүлж харагдуулах, гал түлж орхиод зугтсан түүхийн талаарх мэдээ цөөнгүй. Энэ талаар Чингис хааны аян дайныг өгүүлсэн “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэн зүйл бий. Үүнтэй адил мэдээг Ибн Арабшах өгүүлсэн нь: “нэгэн шөнө өндөрт гарч харвал султаны хоноглосон газарт гал түлж орхисон болохыг үзэв” [İbni Arabşah 2012. s.239] гэдэг.

Эртний хийгээд Дундад зууны цэргийн голлох зэвсэг нь нум сум, илд, байлдааны сүх, бялуу, жад, бамбай байсан нь мэдээж хэрэг. Гэхдээ нүүдэлчдийн хувьд нум сум нь хамгийн чухал зэвсэг нь байсан. Тийм ч учраас бидний энд авч үзэж байгаа ибн Арабшахийн зохиолын дотор ч нум сумны тухай бусад сурвалжийн адил цөөнгүй давтан дурдагддаг. Мөн үүнээс гадна зохиолд нүүдэлчдийн түгээмэл хэрэглэж байсан зэвсгийн тоонд орох сөргөөний талаар өгүүлсэн сонирхолтой мэдээ байна. *Сөргөө* бол морьт цэрэгт ихээхэн хор хөнөөлт зэвсгийн нэг байв.

Эмир Төмөрийн цэрэг Энэтхэгт анх удаа заант цэрэгтэй тулгарсан. Үүнээс өмнө Монголын эзэнт гүрний үед нэгэнтээ тулгарч байсан билээ. Ибн Арабшах өгүүлсэн нь: Зааны учруулах гай зовлонгоос уртаж нэгэн заль зохиов. Эхлээд төмөр сөргөө бэлтгүүлэв. Тэр нь гурван үзүүртэй, ... Энэхүү сөргөөг мянга мянгаар бэлтгүүлэв. Чингээд цэргээ байрыг нь эзлүүлэн зааны эсрэг илгээв. Дараагаар нь шөнө дайны талбарт сөргөөг сацаж орхин зааны учруулж болох гамшгаас сэргийлэв. Улмаар хил хязгаар тогтоон түүнийг их цэрэг давахгүй байх анхааруулга өгчээ. ...Зарим явган цэргийг баруун зүүн талаас ирэх довтолгоог сэргийлэн отолт хийлгэв. ...Заант цэрэг сөргөө бүхий газар довтлон ирсэнд заануудын хөлд шигдэн орох сөргөөнд тэдгээр заанууд үсрэн цовхорч эхэлсэнд тэднийг тулалдааны талбар руу залахыг оролдсон боловч амжилт эс олов. Заанууд зугтахдаа цэрэг, морьдыг гишгэлэн одов. Үүнээс гадна Төмөрийн отолтонд үлдээсэн явган цэрэг үлдсэн цэргийг нь цавчин хөнөөв. Энэтхэгт тэмээ ер үгүй тул заанууд тэдгээрийг (тэмээ) хараад айн зугтах ажээ. Үүний учир Төмөр 500 бөхт тэмээ цуглуулан, тос шингээж багцлан бэлтгэсэн хөвөн давууг тэмээнд ачиж тэдгээр тэмээг морьтны өмнө оруулан илгээв ...заануудын өмнөөс илгээв” [İbni Arabşah 2012. s.169-171] гэдэг.

Аливаа байлдааны ажиллагааг амжилттай явуулах нэгэн үндэс бол *газар зүйн онцлог, давуу байдлыг* чадамгай ашиглах явдал байв. Османы султан Биязит хийгээд Эмир Төмөрийн цэргийн хооронд өрнөсөн тулалдаанд газар зүйн давуутай байдлыг Төмөр олж авч чадсан нь ялалтыг түүний талд болохын нэг шалтгаан болжээ. Энэ талаар ибн

Арабшах бээр “Үнэн хэрэгтээ түүний (Биязитийн) цэргүүд ундны усгүйд харангадаж цангасны учир ялагдав” [İbni Arabşah 2012. s.308] гэдэг.

Мэргэ, задын чулуу:

Нүүдэлчдийн дайн, байлдааны түүхэнд нэг анхаарал татдаг зүйл бол *мэргэ, төлөг буулгах* явдал байв. Монголын эзэнт гүрний дараа Дундад Азид тархан сууж байсан түрэг, монгол хэлтнүүдийн дунд дээрх зан үйл түгээмэл цэрэг, дайны үйлд хэрэглэгддэг байжээ. Тухайлбал, “Тарихи Рашиди”-д 1365 онд болсон нэгэн тулалдааны талаар өгүүлсэн нь:

“Нүүдэлчдийн цэрэг дайтах хүч үгүй

Иймийн учир шидэт чулуунаас тусламж хүсэв

Шидэт чулуу-Яда чулуутай хамт

А 175 (11 фотографий) «Тибет, Монголия и Северный Китай. Фотографии принадлежащие П.К. Козлову и С.Ф. Ольденбургу». На конверте имеется надпись: «Монголы. 1908–1911 гг.». Описание фотографий отсутствует. Мы предполагаем, что они сделаны во время Монголо-Сычуаньской экспедиции (1907–1909 гг.), в результате которой были открыты руины мертвого тангутского города Харакото, обнаружена богатейшая библиотека текстов на тангутском и китайском языках, собраны важные этнографические материалы о народах Монголии. Экспедиция прошла от Кяхты по всей территории Монголии: с севера через Монгольский Алтай на юго-восток через пустыню Гоби до низовья реки Эдзин-гол, затем по территории Северного Китая и Тибета – до Синина и Куку-нора. На фотографиях изображены монголы, проживающие на границе с Китаем, в Северном Китае и в Тибете: группы полуседных кочевников, сокольничии, всадники, люди в национальных одеждах около юрт.

А 176 (86 фотографий). «Тибет, Монголия, Сев. Китай. Фотографии, принадлежащие П.К. Козлову и С.Ф. Ольденбургу». В этой коллекции имеются фотографии из той же Монголо-Сычуаньской экспедиции П. К. Козлова и из археологических экспедиций С. Ф. Ольденбурга в Восточный Туркестан (1909– 1910, 1914– 1915 гг.). Среди фотографий есть изображения буддийских храмов, монахов, религиозной мистерии – цам.

С 11 (55 фотографий в альбоме). Альбом представляет собой рукописное подарочное издание в картонном переплете. На первом листе имеется надпись «Северная Монголия. Ландшафты. Дар ученого Комитета Монгольской народной Республики Академии наук СССР». Это подарок Ученого Комитета Монголии к 10-летию юбилею Монгольской Академии наук, которая была основана на базе Института рукописей и манускриптов (Судар бичгийн хүрээлэн), начавшего свою деятельность в 1921 г. На второй странице Альбома дано его содержание и символы, которыми указывается абсолютная высота фотографируемого природного объекта, абсолютная высота пункта съемки, долгота по Гринвичу и ориентация объекта по сторонам света. В Альбоме 55 фотографий. На всех них изображены места работы в Монголии С.А. Кондратьева, археолога, музыковеда-фольклориста,

путешественника-этнографа, заместителя помощника археологического отряда Тибето-Монгольской экспедиции (1923–1926) П.К. Козлова, а позже – сотрудника Монгольского ученого Комитета. Фотографии, вошедшие в подарочный Альбом, имеются в дневниках экспедиций (1927–1929) С.А. Кондратьева по Северо-Западной Монголии. Характер подписей к фотографиям подтверждает, что Альбом был подготовлен С.А. Кондратьевым.

А 77 (101 фотография). «Виды Монголии из колл. Д. А. Клеменца». Коллекция состоит из 101 фотографии. Д.А. Клеменц был сослан за запрещенную противоправительственную политическую деятельность в Сибирь. Пробыв в Сибири около 15 лет (причем, последние годы – добровольно), изучая антропологию и этнографию народов, населяющих Сибирь и Монголию, Д.А. Клеменц неоднократно предпринимал продолжительные путешествия с научными целями на Алтай, в Монголию, Якутию. С 1897 по 1899 гг. организовывал в Монголии отлов лошадей Пржевальского. Его географические и этнографические труды печатались в сибирских и петербургских изданиях Русского географического общества. Позже, переехав в Санкт-Петербург, он получил должность хранителя Академического этнографического музея Императора Александра III (В настоящее время Российский этнографический музей). Фотографии, хранящиеся в фотоархиве ИВР РАН, относятся к путешествиям Д.А. Клеменца по Монголии. На них изображены природные объекты, люди древнетюркские захоронения–*хэрэгсуры*, тюркские памятники – *балбалы*.

А 114 (39 фотографий). Фотографии этой коллекции принадлежат А.В. Бурдукову, который прожил в Монголии почти 20 лет, пройдя путь от мальчика-рабочего в фирме русского купца Я.Е. Мокина, в услужение к которому он попал в двенадцатилетнем возрасте в 1883 г., до главы Товарищества «Бурдуков и К». Будучи любознательным и талантливым от природы, он не мог не заинтересоваться культурой, историей, языком людей, с которыми соприкасался по работе и в жизни. В 1912 г. А. В. Бурдуков получил от совета Русского географического общества Малую серебряную медаль. В 1921 г. за сочувствие к Советской власти он подвергся преследованию и был вынужден покинуть Монголию. Переехав в Петербург, он преподавал на Восточном факультете в Санкт-Петербургском университете, занимался исследовательской работой. Написал более 20 научных статей. В Архиве ИВР РАН имеется 39 фотографий, сделанных А. В. Бурдуковым на Северо-Западе Монголии

в урочище реки Хангельцык, в Кобдо и в Улясутае, местах, связанных с его проживанием и деятельностью. На них запечатлена этнография и быт монголов: ставка князя, юрта в разобранном виде, сортировка и приготовление к отправке товаров, кочевка русского торговца на летовку, вид летовки, шерстомойка, мойка, сушка и упаковка шерсти в мешки, обед мойщиков шерсти, молотба на быках, овцы на ночлеге, главная улица Кобдо, сад амбани и китайская кумирня Гэсэра в Кобдоской крепости, кобдоская тюрьма.

FAO_A_18. Виды и типы Монголии. 1927. инв. 6. Facs. phot. №166. 1928 - № 716 (43 фотографии). Коллекция фотографий связана с экспедицией Н.Н. Поппе в Монголию в 1927 г. В состав отряда входили монголоеды Б.Б. Бамбаев, В.А. Казакевич, Г.Д. Санжеев. По результатам работы экспедиции на юго-западе от Улан-Батора в долинах рек Толы и Орхона было составлено описание древних сооружений исчезнувших цивилизаций, существовавших в этих местах. Членами экспедиции были обнаружены ранее неизвестные наскальные надписи на монгольском и китайском языках, записаны десятки фольклорных произведений – былин, песен, сказок. Ученые отметили, что этот вид творчества стал отмирать, как факт трансформации хозяйственной жизни. Н.Н. Поппе изучая дагурский язык в Улан-Баторе, пришел к выводу, что в нем много архаичных форм, которые встречаются в наречиях монголов Афганистана. Б.Б. Бамбаев, проводивший исследования на р. Селенге, обнаружил погребения, остатки древних уйгурских городов (VIII–IX вв.), описал свадебные обряды. В.А. Казакевич, работавший в районе Дариганга, собрал большое количество этнолого-лингвистического материала, записал более 20 фольклорных произведений, описал 17 погребений типа *хэрэксур*, исследовал надгробные статуи и сделал вывод об их сходстве со статуями Юга России, выдвинув гипотезу об их тюркском происхождении и о том, что они изображают не убитых врагов, а самих воинов. Кроме того ученый исследовал административную систему управления в Дариганге. Г.Д. Санжеев работал на северо-западе Монголии. Занимаясь изучением этнографии, языка и фольклора дархатов, он сделал выводы о происхождении этого народа от смешения монголов-ойратов с тюрками-урянхайцами и заметил ряд интересных особенностей в устном народном творчестве этого народа. Он обратил внимание на важную роль детей и их любимых животных в дархатских сказках и поэмах, на незначительное

влияние буддизма в их поэтическом наследии. В архиве ИВР РАН имеется альбом из 15 листов с 43 черно-белыми фотографиями. Предположительно, подписи под фотографиями сделаны рукой Н.Н. Поппе. На фотографиях изображены долины рек Хара, Тунхелин, Орхон, монастырь Амарбаясгалант, надпись, найденная в Тухийн суме, шаманские атрибуты шамана Майдари (барабан, медные зеркала, фартук), праздник (*тахилган*) на горе Хайрхан, могильная статуя без головы, одна из фигур буддийского пантеона в храме монастыря Амарбаясгалант, субурганы. Есть групповые портреты монголов, сделанные на р. Хара и в Улан-Баторе.

FAO_A_84 Инв. 25. Ст. инв. III, 340 нова. «Фотографии из поездки по Юго-Восточной Монголии ст[удента] В. Шангина в мае 1905 г.» Альбом 12 листов 16 x 19 см. 24 фотографии 8 x 10.5 см. Фотографии поступили в фотоархив из фонда русского синолога, ботаника географа, почетного члена Петербургского ботанического сада Эмилия Васильевича Бретшнейдера, который в 1866–1884 гг. работал врачом в Пекине. Сведений о том, как в его архиве оказался альбом из 24 фотографий о Юго-Восточной Монголии, принадлежавший В. Шангину, нет. Известно, что в конце апреля 1905 г. по распоряжению Главного штаба в Монголию был направлен под видом датского корреспондента штабс-капитан Россов и состоящий при нем переводчик, студент Восточного факультета Санкт-Петербургского университета В.А. Шангин. Поездка носила разведывательный характер и была связана с военными событиями в этом районе. Задачи поездки сводились к изучению военной ситуации юго-восточных районов Монголии. В настоящее время эти районы находятся на территории Китая (во Внутренней Монголии). Непокойное положение этого края тревожило Россию. Разведчикам предстояло выяснить наличие японских отрядов в Монголии, качество дорог, возможность передвижения по ним военных отрядов, политические настроения местного населения. В результате разведки было выяснено, что в Монголии крупных японских отрядов нет. Есть только шайки хунхузов, состоящих на службе у японцев и действующих под руководством японских офицеров; дороги по границе Монголии удобны для движения, но наступление крупных отрядов невозможно по причине недостатка местных средств; монгольские князья южных хошунов склоняются скорее на сторону японцев. Фотографии дают представление о быте и жизни местного населения Юго-Востока Монголии того времени. Среди них несколько портретов князей в

парадной одежде, командиров и солдат хунхузских отрядов, пейзажи, сцены из жизни монголов, китайские и монгольские храмы, населенные пункты, пытка китайца хунхузами, китаец, казненный хунхузами, цитадель города Чен-Цзя-туня, улица Пекина.

Фотографии о Монголии и монголах, хранящиеся в Институте восточных рукописей РАН выполнены учеными-путешественниками, на них изображена природа Монголии, этнография, быт монголов, портреты людей разных этнических групп. Все они относятся к концу XIX – началу XX века и показывают Монголию того времени.

Сотрудники ИВР РАН участвовали в проекте 10-томного издания фотографий «Монголия и монголы». Был издан альбом «Монголия и монголы в фотографиях Института восточных рукописей РАН». Над альбомом работали сотрудники ИВР РАН: доктор филологических наук И.В. Кульганек (предисловие, составление, подготовка к изданию), кандидат филологических наук Светлана Санджиевна Сабрукова (составление), фотограф Наталия Владимировна Захарова (оцифровка и подготовка фотографий к изданию). Ответственный редактор – академик МАН, генеральный секретарь Международной Ассоциации монголоведов Сампилдондовын Чулуун. В Альбоме представлено 230 фотографий, имеется предисловие, каталог и краткое описание. При подготовке к изданию мы сталкивались с рядом проблем, связанных с их долгим или неправильным хранением. Все они сильно потускнели от времени. Качество фотографий также разное. На некоторых фотографиях произошел выход серебра поверх изображения. В большей степени это касается Альбома шифра С 11. В других фотографиях заметно выцветание изображения. Ряд фотографий имеют заломы, грязь по поверхности, царапины. Многие фотографии из коллекции Д.А. Клеменца изначально были низкого качества. Недостаточная резкость и фотографий А.М. Позднеева. Такому материалу требовалась обработка: увеличение четкости и контрастности, устранение повреждений на лице, фоне, одежде, тоновая коррекция. Работа с такими дефектами занимает время от одного часа до нескольких дней на одну фотографию. Однако все это не снижает ценности фотодокументов. И мы уверены, что Альбом вызовет интерес историков, этнографов, культурологов и всех специалистов, изучающих Монголию.

DOI10.48612/IVRRAN/9xpd-ulzp-2hle

Э. Мөнхцэцэг

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН ДАХЬ НЭГЭН МОНГОЛ-МАНЖ ТОЛЬ БИЧГИЙН ТУХАЙ

Тус өгүүлэлд Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй нэгэн монгол-манж толь бичгийн тухай өгүүлнэ. Энэ толь бичиг нь нийт 93 хуудастай, тайлбаргүй, орчуулгын толь юм. Толийг үйлдсэн хүний нэр, хэзээ найруулж бичсэн зэрэг тодорхойгүй. Уг тольд зөвхөн «а» үсгээр эхэлсэн 1000 орчим үгсийг цагаан толгойн дэсээр байрлуулсан байна. Энэхүү гар бичмэл толь нь монгол-манж толь бичиг найруулж ирснийг илтгэх бидэнд мэдэгдэж буй хоёр дахь баримт болно.

Түлхүүр үгс: гар бичмэл, толь бичиг, а үсэг, монгол толгой үг, манж орчуулга, утга.

Э.Мунхцэцэг

ОБ ОДНОМ МОНГОЛЬСКО-МАНЬЧЖУРСКОМ СЛОВАРЕ ИЗ СОБРАНИЯ НАЦИОНАЛЬНОЙ БИБЛИОТЕКИ МОНГОЛИИ

В статье рассматривается монголо-маньчжурский словарь, который хранится в Монгольской национальной библиотеке. Он является переводным словарем, без толкований. Словарь состоит из одной тетради на 93 листа. В ней отсутствуют дата его написания и имя составителя. Словарь включают в себя более 1000 слов, приводящихся по порядку традиционного монгольского алфавита, которые начинаются только на букву «а». Этот рукописный словарь, как стало известно нам, второе свидетельство существования монголо-маньчжурских словарей.

Ключевые слова: рукописный, словарь, буква а, монгольское заглавное слово, маньчжурский перевод, значение.

Манж нар Хятад орныг эрхшээлдээ оруулан захирсан үеэс улсын албан ёсны хэл манж хэл болж, бүх албан хэргийг манж хэлээр явуулах болжээ. Улс гүрний нийт ард иргэд, төрийн алба хашиж байсан ноёд түшмэдэд манж бичгийг заан сургахын тулд нэн түрүүн толь бичиг, гарын авлагуудыг зохиох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Толь бичиг зохиох ажил XVIII зууны үед илүү эрчимтэй явагдсан бөгөөд энэ үед хоёр хэл, гурван хэл, дөрвөн хэлний толиудыг бар сийлэн

тархаасны зэрэгцээ, таван хэлний гар бичмэл толийг зохион гаргажээ. Хожим эдгээр толь бичигт тулгуурлан гэрийн сургалт болон хувийн хэрэгцээнд зориулсан манж-монгол, монгол-манж гар бичмэл толь бичгүүдийг эмхэтгэж эхэлжээ. Манж-монгол гар бичмэл толь бичгүүд нь тоо хэмжээний хувьд монгол-манж хэлнийхээс илүү олон болно.

Монгол Улсын Үндэсний номын санд монгол-манж хэлний нэгэн гар бичмэл толь 13806/97 гэсэн дансны дугаартайгаар хадгалагдаж байна.

Энэхүү монгол-манж толь нь (цаашид ГБММ гэх) нийт 1 дэвтэр, 93 хуудастай. Хуудасны хэмжээ 27х13 см. ГБММ толийг бүтээхдээ бор өнгийн муутуу цаасыг цагаан өнгийн мяндсан утсаар үдэж товхин, хар бэхээр бийрээр үйлдсэн бөгөөд хавтсыг тусгайлан ялгаж өгөөгүй. Нэг хуудсанд 6 мөрөөр бичсэн. Дэвтрийн хуудсууд дээр шугам татаагүй. Хуудасны дугаарыг хуудас бүрийн «а» тал буюу толийг товхиж үдсэн хэсгийн голд манж (үгээр) болон хятад тоогоор дугаарлажээ. Жишээ нь, ма. *juwan ilan*, хят. 十三 ‘арван гурав’ г.м. Энэ нь уламжлалт манж-монгол хэлний толь бичгүүдийн [1708, 1717, 1771] дугаарлалтай адил байгаа юм. Толийн нэрийг хавтас болон толийн бичвэрийн аль алинд бичиж тэмдэглээгүй. Тиймээс зөвхөн толийн бичвэрээс энэ толь бичгийг монгол-манж хэлний толь болохыг мэдэх бололцоотой аж. Түүнчлэн тус толийг үйлдсэн хүний нэр, хэзээ зохиож бичсэн зэрэг тодорхойгүй болно.

Энэхүү толийг монгол, манж хоёр хэлээр бичсэн. ГБММ тольд цагаан толгойн дэс дарааллыг баримтлан үгсийг толгойлсон бөгөөд тайлбаргүй, орчуулгын толь болно. Тольд нийт 1000 гаруй толгой үг багтжээ. Эдгээр үгсийг тольд оруулахдаа босоо мөрд бичиж, монгол үгийг эхэнд нь, түүний доор тухайн үгэнд онолдох манж орчуулгыг тавьсан байна. Нэг хуудсанд багтах толгой үгийн тоо 2-8-ын хооронд хэлбэлзэнэ.

Энэхүү толь бичгийн бүтэц, агуулгын зарим онцлогийг доор дэлгэрэнгүй авч үзье.

ГБММ толь дахь бүх үг “а” үсгээр эхэлжээ. Тэдгээрийг үндсэндээ уламжлалт монгол цагаан толгойн дарааллаар, тодруулбал үгсийн “а” үсгийн ард орсон үгсийг баримжаалан толгойлсон. Гэхдээ зарим тохиолдолд цагаан толгойн дэс зөрчигдсөн байна. Зохиогчийн сонгож оруулсан үгсийн байрлалыг тодорхой харуулах үүднээс толийн бүх бичвэрийг дөрвөн хэсэгт хуваах бололцоотой юм.

1. 1r-58r хуудсанд *a* үсгийн араас гийгүүлэгч, эгшиг (C+V) орсон үгс байрласан байна. Үүнд, *ana* — *ani* — *anu* — *aqa* / *aya* — *aqu* /

ayu — aba— abi — abu — asa гэх мэтээр 58r хуудсыг дуустал аya — ayu — age — agi / aki — ara — ari — aru хэмээн үргэлжилжээ. ү үсгийг толилохдоо уг үсгийн өмнө тавьдаг нэмэлт тэмдгийг тавиагүй, үүний улмаас хоёрдугаар үед нь q/γ гийгүүлэгч орсон үгс холилдон байрлажээ.

2. 58r-61r хуудсанд зохиогч эхний хэсэгт (үз.: Хүснэгт 1) оруулаагүй орхигдуулсан үгсийг нэмж, үсгийн дарааллаар байрлуулсан байна.
3. 61a-64b хуудсанд *a* ба *yi*-гийн нийлц буюу *ayi* хос эгшиг орсон үгс байрлажээ. Өөрөөр хэлбэл, *ayi* - *ayiγu* - *ayibu* - *ayisi* - *ayida* - *ayila* - *ayima* - *ayija* - *ayira* - *ayila* - *ayid* - *ayil* - *ayily* – *ayims* буюу эхлээд C+V гэсэн үе, дараа нь нэг (C), эсвэл хоёр гийгүүлэгчээр (C+C) төгссөн үгс орсон байна. Эдгээр бүх үгийг хос эгшгийн дараа байрлах гийгүүлэгчийг харгалзан цагаан толгойн дэсээр толгойлжээ.
4. 64v-93v хуудсанд эхний хэсгийн үгсийг үргэлжлүүлж, цагаан толгойн дэсээр жагсаажээ. Өөрөөр хэлбэл, *a* үсгийн араас нэг юм уу (C), хоёр гийгүүлэгч (C+C) орсон үгс байрласан байна. Үүнд, *ar* — *arγ* — *arb* — *ars* — *arš* — *art* — *arč* — *ark* — *arγ* — *and* — *anj* — *ang* — *aγ* — *aγs* — *aγš* — *aγt* — *aγd* — *aγl* — *aγj* — *asγ* — *adγ* — *ab* — *abs* — *abt* — *abd* — *abl* — *abč* — *abj* — *abq* — *abs* гэх мэтээр *amt* — *amč* хүртэл үргэлжилжээ. Гэвч жагсаалтын эхэнд цагаан толгойн дэсийн төгсгөлөөс үл мэдэгдэх шалтгаанаар эхэнд оруулж байрлуулсан *ar* үеэр эхэлсэн үгс байгааг тэмдэглэе. Үүнээс өөр багахан зөрчлүүд мөн бий. *arγ* - аар эхэлсэн үгс жагсаалтын хоёр ондоо хэсэгт салж орсон, тэдгээрийн ихэнх нь эхэнд бичигдсэн боловч, нэг үгийг *ar* - аар эхэлсэн үсгийн төгсгөлд нэмж оруулжээ. Түүнчлэн хоёр газарт *abs* бүхий үгс оржээ. Гэвч эдгээрийн эхний тохиолдолд зөвхөн хоёрхон үг хамаарах бөгөөд онолдох орчуулгагүй бичигджээ.

1-р хүснэгтэд зохиогч эхний хэсгийг зохиож дуусгасны дараа нэмж оруулсан үгс, ө.х. толь бичгийн хоёр дахь хэсэгт орсон нэмэлт үгсээс (т. 58r-61r) үзүүлэв. Нийт 46 толгой үгийг нэмж, эхний хэсгийн эхэнд өгөгдсөн үсгийн нэгэн адил цагаан толгойн дэсээр байрлуулжээ. Хоёр дахь хэсгийн нэмэлт үгсийг эхний хэсгийнхтэй харьцуулж үзэхэд үг нэмэх хэд хэдэн шалтгаан байсан нь ажиглагдлаа. Эхний хэсгийн толгой үгтэй холбоотой холбоо үг (үз.: Хүснэгт 1, № 1, 2, 6, 7), эсвэл энэ хэсэгт ороогүй орхигдуулсан нэг язгуурт үгс (үз.: Хүснэгт 1, № 3, 4, 5, 8, 9), цөөн

хэдэн шинэ толгой үгийг нэмэн оруулж (үз.: Хүснэгт 1, № 10-13), эсвэл эхний хэсэгт орсон толгой үгсийг цөөн тохиолдолд давтан (үз.: Хүснэгт 1, № 14-15) бичжээ. Үг давтагдсан тохиолдол нь маш цөөн, давтах болсон нь тухайн үгэнд онолдох өөр манж орчуулгыг нэмж оруулах шаардлагаас үүдсэн бололтой. Энэ толийн нэг монгол үгэнд их төлөв хэд хэдэн манж орчуулгыг хадсан байдаг. Энэ тохиолдолд сүүлийнхийг нь тухайн монгол үгийн дор жагсаан бичсэн байна. Онолын хувьд иймэрхүү нэмэлт орчуулгыг үндсэн бичвэрт багтаах (жишээлбэл, босоо мөрийн дунд) боломжтой хэдий ч, зохиогч эхний хэсгийн бичвэрийг эмх замбараагүй болгохгүйн тулд нэмэлт үгсийг тусад нь жагсааж бичихийг илүүд үзсэн бололтой.

№	Нэмж оруулсан үгс (хоёр дахь хэсэг дэх) (т. 58г-61г)			Үгс (эхний хэсэг дэх) (т. 1г-61г)		
	толгой үгс	Орчуулга	хуудасны дугаар	толгой үгс	орчуулга	хуудасны дугаар
1.	<i>aγaljin-u silüsber ögesi kimüi</i>	аалзны шүлсээр өгөөш хиймүй	т. 58v	<i>aγalji</i>	аалз	т. 5г
				<i>aγaljin-u silüsü</i>	аалзны шүлс	т. 5г
2.	<i>aγar-tur aγad</i>	агаарт агаад	т. 58v	<i>aγar</i>	агаар	т. 5г
3.	<i>adali-yi inu</i>	адилыг нь	т. 59v	<i>adali</i>	адил	т. 22г-v
4.	<i>adalisiγ</i>	адил шиг		<i>adaliqan-bar ügei</i>	адилханаар үгүй	
				<i>adali nuγud</i>	адилууд	
				<i>adaliqan</i>	адилхан	
				<i>adalisiyamui</i>	адилшаамуй	
5.	<i>adalisiγ-i</i>	<i>id.</i>		<i>adalisiγ</i>	адил шиг	
			<i>adalidqamui</i>	адилтгамуй		
6.	<i>aγur yeketei</i>	уур ихтэй	т. 58v	<i>aγur</i>	уур	т. 10v
7.	<i>amisqal amisqumui</i>	амьсгал амьсгамуй	т. 60г	<i>amisqul</i>	амьсгал	т. 39v
8.	<i>amisqamui</i>	амьсгамуй	т. 60г			
9.	<i>aγalyulan</i>	аялгуулан	т. 60v	<i>aγalyu</i>	аялгуу	т. 50v
10.	<i>abali</i>	авааль	т. 59г	-	-	-
11.	<i>abiyas</i>	авьяас	т. 59г	-	-	-
12.	<i>amidan tamu</i>	амьдын там	т. 60г	-	-	-
13.	<i>aruuqan</i>	аруухан	т. 61г	-	-	-

14.	<i>amui</i>	амуй	т. 60v	<i>amui</i>	амуй	т. 41r
15.	<i>aγudalmui</i>	уудалмуй	т. 58v	<i>aγudalmui</i>	уудалмуй	т. 5v

Хүснэгт 1. Нэг болон хоёр дахь хэсэгт байрласан нэг ижил үеэр эхэлсэн толгой үгс

ГБММ тольд олон утгат, эсвэл ижил бичлэгтэй нэг манж үгээр орчуулагдсан монгол толгой үг цөөнгүй бий. Уламжлалт манж-монгол толь бичгүүдэд ийм монгол үгсийг онолдох манж үгийнх нь дор таслалаар зааглан, эгнүүлэн бичсэн байдаг, энэ нь манж хэлийг гол болгож зохиосон толь бичгүүдийн хувьд зүй ёсны хэрэг юм. Гэхдээ ийм тохиолдол нэгэн монгол-манж хэлний гар бичмэл тольд гарч буйг тэмдэглэмээр байна.¹ Тус тольд монгол үгийн хажуугаар хэд хэдэн монгол үгийг нэг толгой үг болгон зэргэд бичиж, тэдгээрт онолдох нэг манж үгийг доор нь тавьсан байдаг. Эдгээр хэд хэдэн монгол үгсээ толийн өөр газруудад давтан оруулсан бөгөөд ингэхдээ цагаан толгойн дэсийг харгалзан үг тус бүрийн байвал зохих тухай тухайн толгойд давтан толилжээ. Жишээ нь, *kü*-гээр эхэлсэн үгс орсон газарт үгсийн жагсаалт нь *küliemüi*, *kürtemüi*, *tosumui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *amsumui*, *ülemüi* – ма. *alimbi*; *a* толгойтой үгс байгаа газарт *amsumui*, *küliemüi*, *barimui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *tosumui*, *ülemüi*, *kürtemüi* – ма. *alimbi* гэсэн байдлаар бичигджээ [Баярсайхан 2009. х. 97-108]. ГБММ тольд монгол үг тус бүрийг тус тусад нь цагаан толгойн дэсээр байрлуулсан бөгөөд тэр бүрд нэг ижил манж орчуулгыг хадаж өгсөн байна. Үз.: Хүснэгт 2.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>aq-a</i>	<i>da</i>	ах	[т. 2v]	<i>amγulang</i>	<i>elhe</i>	амгалан	[т. 40v]
<i>amasar</i>	<i>da</i>	амсар	[т. 35r]				
<i>aqamad</i>	<i>da</i>	ахмад	[т. 58r]				
<i>aγarča</i>	<i>da</i>	аарц	[т. 58v]				
<i>abali</i>	<i>da</i>	авааль	[т. 59r]	<i>alyur</i>	<i>elhe</i>	алгуур	[т. 81r]
<i>ayimay-un noyan</i>	<i>da</i>	аймгийн ноён	[т. 63v]				
<i>alda</i>	<i>da</i>	алд	[т. 83v]				

Хүснэгт 2. Нэг ижил манж үгээр орчуулагдсан монгол толгой үгс

¹ Энэхүү толь бичиг нь МУИС-ийн Монгол хэл шинжлэлийн тэнхимд хадгалагдаж байна. Тус тольд дансны дугаар байхгүй болно.

Эсрэгээрээ, нэг монгол үгийг ойр төстэй утга илтгэх өөр өөр манж үгээр орчуулсан тохиолдол ГБММ толь бичигт тааралдав. Энэ тохиолдолд онолдох бүх манж орчуулгыг нь монгол үгийн доор салгалгүй хамт бичсэн бөгөөд монгол хэлийг гол болгож зохиосон бүхий л толь бичгийн хувьд энэ нь зүй ёсны хэрэг билээ. Үз.: Хүснэгт 3.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудас-ны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудас-ны дугаар
<i>Atar</i>	<i>yabi,</i>	атар	[т. 23г]	<i>amur</i>	<i>fu nimaha</i>	амар	[т. 41v]
	<i>šunehe,</i>						
	<i>dooran,</i>						
	<i>yabigan</i>				<i>elhe</i>		

Хүснэгт 3. Хэд хэдэн манж үгээр орчуулагдсан монгол толгой үгс

ГБММ тольд нэг ижил утга илтгэдэг, өөр өөрөөр бичигддэг монгол үгсийг энд тэнд салгаж оруулалгүй, цагаан толгойн дэсээр ар араас нь (бие даасан толгой үг шиг) цувуулан бичсэн байна. Ингэж бичихдээ тухай тухайн хувилбар бүрд манж орчуулгыг онолдуулан тавьжээ. Ийм үгс тольд цөөнгүй байгаа юм. Үз.: Хүснэгт 4. Жишээ нь:

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудас-ны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудас-ны дугаар
<i>ama</i>	<i>angga</i>	ам	[т. 34v]	<i>araddayiki</i>	<i>urseiingge</i>	ардынх	[т. 54v]
<i>am-a</i>	<i>angga</i>		[т. 34v]	<i>arad-un ki</i>	<i>urseiingge</i>		[т. 54v]

Хүснэгт 4. Хэд хэдэн хувилбараар бичигддэг монгол толгой үгс

Ийм онцлогийг ГБММ тольд гарч буй үгсийн манж орчуулгаас мөн олж харах боломжтой. Гэхдээ ийм тохиолдол маш ховор. Энэ тохиолдолд манж үгсийн өөр өөр бичлэгийг харгалзах толгойн үгийнх нь дор эгнүүлэн жагсаажээ. Үз.: Хүснэгт 5.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>alayčin</i>	<i>alhata, alhacin, alha</i>	алагчин	[т. 29v]	<i>ajiry-a</i>	<i>ajirgan, ajirhan</i>	азарга	[т. 48г]

Хүснэгт 5. Манж үгсэд гарч буй хэд хэдэн бичлэгийн хувилбар

Түүнчлэн ГБММ тольд зарим толгой үгийн дараа тэдгээр үгээр эхэлсэн холбоо үг, нийлмэл үг, эсвэл хоршоо үгийг оруулсан байдаг. Ийм үг арав орчим байна. Үүнд, «уул» (мо. *aγula* – ма. *alin*), «уушги» (мо. *aγuski* – ма. *ufuhu*), «алаг» (мо. *alag* – ма. *alha*), «ам» (мо. *ama* – ма. *angga*), «амь» (мо. *amin* – ма. *ergen*), «ачлалт» (мо. *ačilaltu* – ма. *hoyoošun*), «айлтгах» (мо. *ayiladqaqu* – ма. *wesimbure*), «алт» (мо. *altan* – ма. *ayisin*). Ихэнх холбоо үг нь «алт» хэмээх үгэнд өгөгджээ. Эдгээр үгийг бүгдийг нь бие даасан толгой үгийн нэгэн адил тольд оруулж, «алт»-ын ард орсон хоёр дахь үгээр баримжаалан, цагаан толгойн дэсээр дараалуулжээ.

Орчин цагийн монгол хэлний толь бичгүүдэд «алт» гэсэн үг оролцсон олон холбоо үг орсон байдаг ч, ГБММ толь дахь жагсаалт нь бүрэлдэхүүний хувьд ялгаатай байгааг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр холбоо үг нь гурав ба таван хэлний зүйл хуваасан манж хэлний толь бичгүүдэд мөн орсон, гэсэн ч тэдгээрийг сэдвийн хувьд өөр өөр зүйлд байрлуулсан байдаг учраас хайж олоход бэрхшээлтэй байдаг. Үүнтэй холбогдуулж тэмдэглэхэд, монгол хэлний зарим хуучны тайлбар тольд холбоо үгсийг толгой үгийн үүргээр оруулсан бол [Šayja 1994; Лувсандэндэв 1959-1966], заримд нь толгой үг болгоогүй, үгийн үүрийн дотор багтаасан байдгийг дурдууштай.

Холбоо үгсийн жагсаалтын ихэнхийг ургамал, шувуу, од эрхэс, эзэн хааны ордны алтаар хийсэн янз бүрийн эд зүйлсийг тодотгосон үгс эзэлж байна. Эдгээр үгийг крилл монгол руу хөрвүүлэхдээ ургамлын нэр томьёоны толь [Мижиддорж 1973; Өлзийхутаг 1984], монгол хэлний товч тайлбар толийг [Цэвэл 1966] ашиглав.

«Алт» (мо. *altan*, ма. *ayisin*) хэмээх үг оролцсон бүх холбоо үгийг доор жагсаан үзүүлье.

- *altan artu körüsü* ‘алтан арт хөрс’, *altan elgügürtü külis* ‘алтан өлгүүрт хүлс’, *altan ukiyal-un γadur-a* ‘алтан угаалын гадар’, *altan üsüg-ün nom-un küriy-e* ‘алтан үсгийн номын хүрээ’, *altan iй-e-tü ča(m)čuy* ‘алтан үет цацаг’, *altan nidütü ularu* ‘алтан нүдэт улар’, *altan nidün biljuiqai* ‘алтан нүдэн бялзуухай’, *altan nilbuyuur* ‘алтан нялбуур’, *altan qongqari* ‘алтан хонхорь’, *altan balta süke* ‘алтан балт сүх’, *altan bojiry-a* ‘алтан божирго’, *altan sandali* ‘алтан сандал’, *altan soličal tulyurun üsüg* ‘алтан сольцол тулгарын үсэг’, *altan dayaqu osei ildü* ‘алт дагах өшөө илд’, *altan tosquyur čorgilqu* ‘алтан тосгуур цоргилох’, *altan longqu* ‘алтан лонх’, *altan anasi odun* ‘алтан анааш од’, *altan melekei tulyarun*

üsüg ‘алтан мэлхий тулгарын үсэг’, *altan mörin-dü kigiri* ‘алтан мөрөнд хиур’, *altan čögürsü saba* ‘алтан цүүрс сав’, *altan küjin-ü bayburi* ‘алтан хүжний багвар’, *altan kögürig* ‘алтан хөөрөг’, *altan dan seüke* ‘алтан дан сүйх’, *altan tüsilgetü sandali* ‘алтан түшилгэт сандал’, *altan sirdü ile seüke* ‘алтан ширт ил сүйх’, *altan jīgür* ‘алтан жигүүр’, *altan julai* ‘алтан зулай’;

- *altan utasu* ‘алтан утас’, *altan utasu torγumui* ‘алтан утас торгомуй’, *altan oriyangγu čēceg* ‘алтан ороонго цэцэг’, *altan γadasu odun* ‘алтан гадас од’, *altan qačar* ‘алтан хацар’, *altan qariyačai* ‘алтан хараацай’, *altan qumaki čēceg* ‘алтан хумхи цэцэг’, *altan γuryuldai* ‘алтан гургалдай’, *altan qunday-a čēceg* ‘алтан хундага цэцэг’, *altan badir čēceg* ‘алтан бадир цэцэг’, *altan badm čēceg* ‘алтан бадам цэцэг’, *altan biljuiqai čēceg* ‘алтан бялзуухай цэцэг’, *altan seyimekeyileg čēceg* ‘алтан сиймхийлэг цэцэг’, *altan sirkegtü torγ-a* ‘алтан ширхэгт торго’, *altan takiy-a* ‘алтан тахиа’, *altan dusul čēceg* ‘алтан дусал цэцэг’, *altan luutu buu* ‘алтан луут буу’, *altan lu terege* ‘алтан луу тэрэг’, *altan čegečēükei* ‘алтан цэгцүүхэй’, *altan curbadai* ‘алтан цуравдай’, *altan jiyasu* ‘алтан загас’, *altan julа čēceg* ‘алтан зул’, *altan jürjei* ‘алтан жүрж’, *altangqu čēceg* ‘алтанхуа цэцэг’.

ГБММ тольд үйл үгийн толь бичгийн хэлбэрийн (-*mui*²) зэрэгцээ үйл үгийн бусад хэлбэрийг мөн оруулсан байна. Нэг үйл үгэнд дагуулсан бүтээврийн нийт тоо 1-6-ын хооронд хэлбэлзэж байна. Энэ онцлогийг мөн Чин улсын үед зохиогдсон манж-монгол хэлний толь бичгүүдээс хялбархан олж харах боломжтой. Тиймээс ГБММ тольд энэхүү уламжлал тусгагдсан болох нь тодорхой байна. Жишээ болгон толь бичгээс хоёр үйл үгийг сонгож 6-р хүснэгтэд үзүүлэв.

	Хэлбэрүүд	мо.	ма.	мо.	ма.
		<i>abla-</i> ‘авла-’	<i>abla-</i> ‘авла-’	<i>abira-</i> ‘авир-’	<i>tafa</i> ‘авир-’
1.	мо. - <i>mui</i> ² , ма. - <i>mbi</i> (IMPF.FINT)	<i>abla-mui</i>	<i>abla-mbi</i>	<i>abari-mui</i>	<i>tafa-mbi</i>
2.	мо. - <i>lča</i> ² - <i>mui</i> ² , ма. - <i>ndu-mbi</i> (COOP-IMPF.FINT)	<i>abla-lča-mui</i>	<i>abla-ndu-mbi</i>	<i>abari-lča-mui</i>	<i>tafa-ndu-mbi</i>
3.	мо. - <i>γul</i> ² - <i>mui</i> ² , ма. - <i>bu-mbi</i> (CAUS-IMPF.FINT)	<i>abla-γul-mui</i>	<i>abla-bu-mbi</i>	<i>abari-γul-mui</i>	<i>tafa-bu-mbi</i>
4.	мо. - <i>ldu</i> ² - <i>mui</i> ² , ма. - <i>nu-mbi</i> (REC-IMPF.FINT)	<i>abla-ldu-mui</i>	<i>abla-nu-mbi</i>	<i>abari-ldu-mui</i>	<i>tafa-nu-mbi</i>

5.	мо. $-r-a^2 + od-mui$, (DER од-IMPF.FINT) ма. $-na-mbi$ (DER-IMPF.FINT)	<i>abla-r-a</i> <i>odmui</i>	<i>abla-na-</i> <i>mbi</i>	<i>abari-r-a</i> <i>odmui</i>	<i>tafa-na-mbi</i>
6.	мо. $-r-a^2 + ire-mui^2$, (DER ир-IMPF.FINT) ма. $-nji-mbi$ (DER-IMPF.FINT)	<i>abla-r-a</i> <i>iremüi</i>	<i>abla-nji-</i> <i>mbi</i>	<i>abari-r-a</i> <i>iremüi</i>	<i>tafa-nji-mbi</i>
7.	мо. $-ba^2$, ма. $-ha^3 / -ka^3 / -ngka$ (PERF.PART)			<i>abari-ba</i>	<i>tafa-ka</i>

Хүснэгт 6. Өөр өөр бүтээврээр хэлбэржсэн үйл үгс

Дээр дурдсан үйлийн хэлбэрүүдээс гадна нэр үгийг олон тооны хэлбэрээр хэлбэржүүлэн тольд оруулсан байдаг. Жишээ нь, *abay-a egeci* ‘авга эгч’ — *abay-a egeci nar* ‘авга эгч нар’, *abay-a nar* ‘авга нар’, *abay-a berged* ‘авга бэргэд’, *abay-a kürgen aq-a nar* ‘авга хүргэн ах нар’. Түүнчлэн *ali* ‘аль?’ хэмээх төлөөний үгэнд зарим тийн ялгалыг залгаж *ali-ača* (ABL), *alin-i* (ACC), *alin-dur* (DAT), мөн ‘арав’ гэсэн тооны нэр (мо. *arban*, ма. *juwan*), түүний *arbaduyar* ‘аравдугаар’, *arbayula* ‘арвуулаа’, *arbayad* ‘арваад’, *arban* ‘арав’, *arbanta* ‘арвантаа’ хэмээх хэлбэрүүдийг бие даасан толгой үгийн түвшинд авч үзжээ.

ГБММ толийг зохиогч тольдоо монгол үгсийг манж орчуулгын хамт нягт нямбай, тодорхой эрэмбэ дарааллаар толилуулсан байгаагаас харахад бичиг үсгийн өндөр боловсролтой хүн байсан нь тодорхой байна. Түүний бичлэгийн онцлогоос дурдвал *γ*, *n* үсгүүд нь дуудлагыг ялгах нэмэлт тэмдэггүй, *č* ба *j*, *γ* ба *ν* гийгүүлэгч үсгүүд нь ижил байдлаар бичигдсэн бөгөөд эдгээр нь 17 дугаар зууны монгол хэлний бичгийн дурсгалд түгээмэл тохиолддог нийтлэг онцлог юм.

Толь бичигт алдаатай бичсэн, нямбай хандаагүй тохиолдол мэр сэр байна. Тухайлбал, монгол хэлний *ани* хэмээх хамаатуулах нөхцөлийг *aniu* гэж буруу бичсэн [т. 2r], *adaliqan-bar ügei* ‘адилхан бэр үгүй’ гэдэг үгсэд орсон *l* гийгүүлэгчийн эврийг бичээгүй [т. 22r], түүнчлэн *ablaldumui* ‘авлалдмуй’ [т. 15r] болон *aburamui* ‘авармуй’ [т. 18r] хэмээх үгс дэх *-mui* бүтээвэрт орсон *m* үсгийн махбодийг буруу тийш чиглүүлж бичсэн, үүнээс болж эдгээр үгийг *ablaldului*, *aburalui* гэж уншихад хүрч байна. Зохиогчийн хайнга хандсаныг илэрхийлэх нэг том нотолгоо бол 79r-р хуудсанд монгол үгсийн манж орчуулгыг орхигдуулж, бичээгүй байгаа явдал. Тодруулж хэлбэл, тус хуудсанд буй нийт 8 монгол толгой үгэнд (*adqumal* ‘атгамал’, *aba* ‘ав’, *ab adali* ‘ав адил’, *ab ariyun* ‘ав ариун’, *ab sab* ‘ав сав’, *abqu* ‘авах’, *absa* ‘авс’, *absalamatui* ‘авсалмуй’) манж орчуулгыг хийж дагалдуулаагүй байна.

Энэхүү монгол-манж хэлний толийн нэг дэвтэрт хийсэн судалгаанаас ажиглахад тус толь бичиг нь зөвхөн «а» биш, монгол цагаан толгойн бусад үсгээр эхэлсэн үгсийг багтаасан олон дэвтрээс бүрдсэн байх магадлалтай гэсэн дүгнэлтийг хийж болмоор байна. Толийн гарчиг, зохиогчийн нэр, зохиогдсон цаг хугацаа тодорхойгүй зэрэг нь энэ таамаглалыг давхар баталж байгаа юм. Учир нь ийм төрлийн мэдээллийг толийг зохиож дууссаны дараа буюу толийн төгсгөлд бичдэг уламжлалтай.

Зөвхөн эхний дэвтэр байгаа тухайд, толь бичиг зохиохоор төлөвлөсөн боловч төлөвлөсөндөө хүрч, бүрэн толь болгож чадаагүй байхыг үгүйсгэх аргагүй гэсэн саналыг дэвшүүлэх боломжтой байна.

Аль нь ч байсан толийн цаас, бичгийн хэв, дугаарлалт, цөөн тооны алдаа мадаг болон толь бичигт нэр байхгүй зэргээс үзвэл толь бичгийг бичиг үсгийн боловсролтой хүн хувийн хэрэгцээндээ зориулж үйлдсэн нь илэрхий байгаа бөгөөд, гар бичмэл толийг манж-монгол толь бичигт суурилан зохиосон гэж үзэх боломжийг өгч байгаа юм.

Мөн энэ толь бичиг, түүний бүтэц, агуулгыг боловсруулахдаа ул суурьтай, сайтар нягтлан шинжилж хандсан болохыг хэлж болно. Нөгөөтэйгүүр, энэ толь бичиг бүрэн бус тул дээр өгүүлсэн баримтад тулгуурлан бүрэн дүүрэн дүгнэлт хийх боломжгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Одоогийн байдлаар маш цөөн тооны монгол-манж толь бичиг бидэнд мэдэгдэж байна. Энэхүү гар бичмэл толь нь монгол-манж хэлний толь бичиг зохиогдож байсныг илтгэх хоёр дахь баримт болно. Тиймээс уг толь бичиг нь монгол толь бичгийн судлалд сонирхолтой хэрэглэгдэхүүн болох билээ.

Товчилсон үгс

ГБММ – гар бичмэл манж-монгол толь

ма. – манж

мо. – монгол

хят. – хятад

ABL – гарахын тийн ялгал

ACC – заахын тийн ялгал

CAUS – үйлдүүлэх хэв

COOP – хамтран үйлдэх хэв

DAT – өгөх оршихийн тийн ялгал

DER – үг бүтээх дагавар

IMPF.FINT – одоо цагийн хэлбэр

PERF.PART – өнгөрсөн цагт үйлт нэр
REC – харилцан үйлдэх хэв

Ном зүй

Сурвалж

Монгол-манж толь бичиг. МУҮНС. Монгол судлал, гар бичмэл номын фонд.
Д/д 13806/97.

Han-i araha manju gisun-i buleku bithe «Хааны бичсэн манж үгний толь бичиг» (1708). Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Манж номын хөмрөг. Шифр С 48.

Han-i araha manju monggo gisun-i buleku bithe «Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг» (1717). Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Монгол номын хөмрөг. Шифр F 319.

Han-i araha ponggime togtobuha manju gisun-i buleku bithe; хят. Yuzhi zengding Qingwen jian (御製增訂清文鑑) «Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг». Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Манж номын хөмрөг. Шифр С 29.

Ном ба өгүүлэл

Баярсайхан 2009: *Баярсайхан М.* Монгол манж толь бичгийн уламжлал дахь нэгэн дурсгал //Acta Mongolica, Centre for Mongol Studies, Dedicated to the 80th Birthday of professor Igor de Rachewiltz. 2009. Volume 9(320). X. 97-108.

Лувсандэндэв 1959: *Лувсандэндэв А.* Misig., Batu-Včir. Gucin jiruyatu tayilburi toli // 1959-1966.Corpus Scriptorum Mongolorum.Instituti Linguae et Litterarum Comiteti Scientiarum et Educationis Altae Reipublicae Populi Mongoli. УБ., ШУДБХ-ийн Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар. 1959. Т-I, fasc.1-2. 23 х, 48 х; 1960 - Т-I, fasc.3-7. 28 х, 37 х, 45 с, 43 х, 60 х; 1961 - Т-I, fasc.8-12. 32 х, 36 х, 41 х, 39 х, 35 х; 1966 - Т-I, fasc.13. 45 х; 1962 - Т-I, fasc.14. 47 х.

Мижиддорж 1972: *Мижиддорж Го.* Монгол-орос-латин-төвд-хятад хэлээр хавсарсан ургамлын нэр томьёо (Ботаническая терминология монгольско-русско-латинско-тибетско-китайская) //Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 89-90. ШУА. УБ., 1972.

Өлзийхутаг 1984: *Өлзийхутаг Н.* Бүгд Найрамдах Монгол Ард улсын гуурст ургамлын латин-монгол-орос нэрийн толь (Латинско-монгольско-русский словарь названий таксонов сосудистых растений Монгольской Народной Республики).Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 129-133. ШУА. Улаанбаатар., 1984.

Цэвэл 1966: *Цэвэл Я.* Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар., 1966.

Šaγja 1994: *Šaγja.* Erikü-y-e kilbar bolγan jokiyaγsan mongyol ügen-ü tayilburi Čindamani-yin erike. Begejin. 1994.

DOI10.48612/IVRRAN/bzva-13r4-mfp2

Б.Нацагдорж
О.Оюунжаргал

“ХҮРЭЭНИЙ ХЭРГИЙН ЗҮЙ (庫倫事宜)”
ХЭМЭЭХ СУРВАЛЖИЙН ТУХАЙ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь XVII зуунд анх Жавзандамба хутагтын Хүрээ хэмээн сууриа тавьжээ. Манж Чин улсын ноёрхлын үед Халхын зүүн хоёр аймаг, Жавзандамба хутагтын шавийн захиргаа болон Оростой харилцах хэргийг хариуцсан сайдыг Манжийн талаас томилон суулгах болсон тул Хүрээ нь говийн арын Монголын чухал зангилаа газрын нэг болсон байна. Манж Чин улсын үеийн Хүрээний сайдын газрын албан үүрэг, эрх хэмжээг судлахад архивын анхдагч эх сурвалжууд хангалттай боловч тухайлан Хүрээний сайдын газрын эрх үүргийг тодорхойлон бичсэн зохиол одоог хүртэл мэдэгдээгүй байсан юм. Иймээс манж болон хятад хэлээр хавсарган бичсэн Хүрээний хэргийн зүй (庫倫事宜) хэмээх сурвалж Япон улсад хадгалагдаж буйг судлан шинжилж үзсэн үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үг: Хүрээний хэргийн зүй, 庫倫事宜, Хүрээний сайдын газар, сайд ван Юндэндорж.

B.Natsagdorj,
O.Oyunjargal

ON THE SOURCE CALLED KU-LUN SHI-YI 庫倫事宜

Ulaanbaatar, the capital city of Mongolia, was first founded in the 17th century as the Khuree of Jebzundamba Qutuytu. During the rule of the Manchu Qing Dynasty, Khuree became one of the important administrative hubs of Mongolia on the north side of the Gobi, since the Manchus established here the office of Governor of Khuree to administer two eastern Aimag of Khalkh and the Great Disciple of the Jebzundamba Qutuytu and the relations with Russia. Although, we have sufficient primary archival sources to study the duties and responsibilities of the Governor of Khuree during the Manchu Qing period, until recently we did not have the written sources specifically dedicated to the office of the Khuree Governor. Therefore, we present the results of the research and analysis of the source called 庫倫事宜, written in Manchu and Chinese, kept in Japan.

Keywords: the Affairs of Khuree, 庫倫事宜, Governor's Office of Khuree, Governor and Prince Yundendorji.

Сурвалжийн тухай

Энэхүү “Хүрээний хэргийн зүй (kulun shiyi, 庫倫事宜)” хэмээх хятад нэр бүхий манж, хятад хэлээр хавсарсан сурвалж нь эдүгээ Япон улсын Осака их сургуулийн харьяа номын сангийн Гадаад судлалын их сургуулийн ховор номын хөмрөгт (бүртгэлийн дугаар 90000109604, захиалгын дугаар Q210.390) хадгалагдаж байна. Үүнд, юуны өмнө тус сурвалжийн тухай мэдээллийг анх өгсөн Япон улсын Соока их сургуулийн профессор Мүраками Нобү-аки, хэвлэх болон хуулбарлах зөвшөөрлийг найр тавин өгсөн тус номын сан, мөнхүү зөвшөөрлийг авахад туслалцаа үзүүлсэн Осака олон улсын их сургуулийн хүндэт профессор Мацүда Коичи, Осака их сургуулийн профессор Мацүи Дай нарт гүн талархал илэрхийлье.

Тус сурвалж нь дорно дахины уламжлалт дэвтэр хэлбэртэй товхисон 24.9×13.1cm хэмжээтэй, тогтуун хичээнгүй тигээр бэхээр бичсэн 115 хуудас бүхий бөгөөд нүүр хавтсанд дээр дурдсан номын сангийн бүртгэлийн дугаарыг наасан бөгөөд дотор талд сурвалжийн нэрийг 庫倫事宜 (Хүрээний хэргийн зүй) хэмээн ханз үсгээр зүүн дээд буланд улаан өнгийн цаасан дээр тусгайлан бичиж наажээ. Манж хэлний бичвэрийг нэг нүүрт 8 мөрөөр бичсэн бол хятад хэлний бичвэр нь нэг нүүрт 9 мөр байна. Манж хэлний бичвэр нь 3-р хуудаснаас эхэлж, 104-р хуудсанд дуусч байна. Үүнээс хойш тус зохиолын хятад бичвэрийг хавсарган үдсэн байх бөгөөд уг эх нь хятад номын толгой эхэлдэг зуршил ёсоор 114-р хуудаснаас эхэлж, 106-р хуудсанд хүрээд дуусч байна. Уг хоёр эхийг тус тусад нь зохион бичээд нийлүүлэн нэгэн дэвтэр болгож үджээ.



Манж эхийн эхний хуудасны баруун гар талын цулгай хэсэгт, дугуй хүрээнд тойруулан 大阪外国語學校 図書課 буюу Осака Гадаад хэлний сургууль, Номын сангийн салбар, голд нь 大正15.3.26 буюу Тайшоогийн 15 оны 3 сарын 26 хэмээх огноо болон 10960 хэмээх дугаар бүхий тамга, түүний доор улаан хүрээ бүхий дээр дурдсан бүртгэлийн дугаар бүхий дардас даржээ. Эндээс үзвэл, тус сурвалж анх Осакагийн Гадаад хэлний сургууль, хожмын Осакагийн Гадаад хэлний их сургуулийн¹ номын санд Тайшоогийн 15 буюу 1926 онд бүртгэгдсэн аж.

Тус сургуулийн номын сангийн бүртгэлд, уг сурвалжийг, “зохиогч тодорхойгүй, зохиогдсон оныг Төр гэрэлтийн гутгаар он” хэмээгээд, сурвалжийн нэрийг манжаар оноож, катакана үсгээр, “へセイ、タクラハ、クルン、デ、テフヒ、バイタ、イチヒヤラ” буюу *hesei takūraha kurun de tehuhi baita icihiyara* хэмээн тэмдэглэсэн агаад монголчилбол, “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэх” болно. Үргэлжлүүлэн, “Сурвалжийн уг нэрийг орчуулбал, Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэх” утгатай, өөрөөр хэлбэл сурвалжийн агуулга нь Зарлигаар зарсан тамга бүхий Хүрээний хэрэг шийтгэгч сайдын түшмэлийн тогтолцоо бөгөөд цалин хөлс, түшмэл, морь унаа зэргийг дэлгэрэнгүй дурдсан” хэмээн тодорхойлсон нь тус сургуулийн манж хэлний багш Ватанабэ Шигэтароо (*watanabe shigetaro*, 渡部薫太郎) болно [Watanabe 1932, 29-30].

1861 онд Япон улсын Нара мужид төрсөн Шигэтароо Ватанабэ англи хэл сурч, харилцаа холбооны ажилтан, хуурай замын цэргийн орчуулагчаар ажиллаж байгаад 1908 онд тухай үед Японы мэдэлд байсан Манжуур, Солонгосын хойгийн зааг Гандо² нутагт очиж, 1924 он хүртэл ажиллаж амьдрахдаа нутгийн манж хүмүүсээс манж хэл сурч, улмаар 1925-1936 он хүртэл буюу нас барах хүртлээ Осакагийн гадаад хэлний сургуульд манж хэл заажээ. 1922 онд байгуулагдсан Осакагийн гадаад хэлний сургуулийн анх 9 гадаад хэл үзэж байсны нэг нь монгол хэл болно. Тус сургуулийн оюутнууд үндсэн болон хавсарга хоёр хэл үзэж байснаас, монгол хэлний ангийн хавсарга хэл нь манж хэл байв [Jin Tingshi 2017, 61-83]. Тийнхүү Шигэтароо Ватанабэ бээр манж хэл заахын сацуу манж хэлний сурах бичиг, хэлний зүй, манж номын

¹ Осакагийн Гадаад хэлний их сургууль нь 2007 онд Осакагийн их сургуультай нэгдэж, тус сургуулийн Гадаад судлалын сургууль болжээ.

² Тус нутагт түрэн орсон солонгосуудын өгсөн нэр Гандо (間島), түүний япон дуудлага Кантоо. Өнөөгийн БНХАУ-ын Жилин мужийн Яньбянь солонгос угсаатны өөртөө засах жөү.

бүртгэл, Алтан улсын судар дахь нэрийн тайлбар, зүрчин үсгийн судалгаа хийж хэвлүүлжээ [Uehara 1966, 1967]. Өөрөөр хэлбэл, XX зууны эхээр манж нарын уугуул нутагт одож, 48 насандаа манж хэл сурч, улмаар 10 гаруй жил Осакагийн гадаад хэлний сургуульд манж хэл заасан Ш.Ватанабэгийн цуглуулсан буюу бүртгэсэн манж номын дотор тус “Хүрээний хэргийн зүй” хэмээх сурвалж байжээ. Харамсалтай нь чухам хаана хэнд байсан тус сурвалж хэзээ, хэрхэн түүний гарт хүрсэн нь тодорхойгүй байна.

Сурвалжийн зохиогч, зохиогдсон он цаг

Сурвалжид зохиогч хийгээд уг зохиолыг бичиж дуусгасан он цагийг тодорхой дурдаагүй боловч ойролцоогоор тодорхойлж болох хэдэн сэжүүр буй. Үүнд, манж хэлний бичвэр нь Сайшаалтай ерөөлтийн 25-р (1820) оны 11 сарын 11 хэмээн дуусч байгаа боловч уг эхийн дотор Төр гэрэлтийн 3-р (1823) он хүртэл тэмдэглэсэн дансыг Хүрээний сайдын яаманд хадгалж буй тухай дурдсанаас үзвэл, юу ч гэсэн уг зохиолыг 1823 оноос хойш зохиожээ. Гэхдээ 1827 оноос өмнө болов уу. Үүний учир нь уг сурвалжийн зохиогч лугаа холбогдоно.



Хүрээний сайд, ван Юндэндорж

(*Mongoleireise zur späten Goethezeit: Berichte und Bilder von der russischen Gesandtschaftsreise 1805/06*


(=Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland, suppl. vol. XIII), 1971.)

Зохиогчийн тухайд, манж бичвэрт, “*Сайшаалтай ерөөлтийн арван хоёрдугаар* (1807) онд *Зарлигаар зарсан Хүрээнд сууж тэргүүлэн хэрэг шийтгэгч сайд, шадарт явах халхын засаг төрийн жүн ван, төрийн эфү миний хошууны эр цээлсэн данс*” хэмээгээд, Халхын Түшээт хан аймгийн нэгэн засаг хошууны хүн амын дансыг оруулсан нь Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд, төрийн жүн ван, төрийн эфү Юндэндоржийн хошууны данс байна. Тиймээс уг сурвалжийг зохиогч нь, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдаар тасралгүй 44 жил ажилласан халхын засаг, төрийн жүн ван төрийн эфү Юндэндорж болно.

Тэрбээр 1765 онд Халхын Түшээт хан аймгийн Дундад баруун этгээдийн хошууны засгийн төрийн жүн ван бөгөөд анх Хүрээнд сууж хэрэг шийтгэсэн сайд, төрийн эфү Санжайдоржийн монгол хатнаас төржээ. Эцэг Санжайдоржийг 1778 онд нас барахад, 13 настай (хий насаар) байсан Юндэндоржийг, эхийн хамт Хүрээнээс Бээжин хотноо шилжүүлэн суулгаж, түүнээс хойш дотор ордонд өсөж хүмүүжжээ. Юндэндоржийн эхийн тухайд тодорхой мэдээ үгүй авч, *wu* хэмээх дуудлагатай ханз үсгээр тэмдэглэсэн буюу ү-у авиагаар эхэлсэн овогтой, ойр төрөл нь Хүрээний хамба номун хан Жамбалдорж, хамба Шагдар хэмээх ах дүү хоёр аж[Wulanbagen 2016, 123-130]. Тэгээд 1779 онд эцгийн засаг төрийн жүн ван хэргэмийг залгамжилж, төрийн эфү болсон Юндэндорж 1783 онд Түшээт хан аймгийн туслагч жанжин, Хүрээний хэрэг шийтгэгч сайдаар томилогдож, 1827 оны 11 сард нас барах хүртлээ уг тушаалыг хашсан билээ [Бао 1994, 514-515]. Дээр дурдсанчлан тус сурвалжийг 1827 оноос өмнө буюу Юндэндоржийн нас барахаас өмнө зохиогдсон хэмээсэн учир ийм болно.

Хүрээний сайд Юндэндорж нь улс төрийн зүтгэлтэн байгаад зогссонгүй Монголын эрдэм соёлыг дэлгэрүүлэхэд багагүй хувь нэмэр оруулсны нэг гэрч нь, хуучин цагийн монголчуудын дунд ихэд тархсан *mongyol-un jayun üsüg orusibai* хэмээх монгол үсгийн цагаан толгойг зохиосон явдал болно. Нийт монголчуудын дунд барламал, гар бичмэл хуулбараар ихэд өргөн дэлгэр тархсан энэхүү цагаан толгойг Тэнгэрийн тэтгэсэний 54-р (1789) онд Халхын Хүрээний сэцэн далай шанзодба Дамчойравжаа дуртгаснаар Хүрээний сайд ван Юндэндорж зохиосон боловч энэхүү цагаан толгой нь нийтэд Дамчойравжаагийн цагаан толгой хэмээн алдаршчээ. Үүний учир нь, уг цагаан толгойг анх Хүрээнд барлахад ямар нэг шалтгаанаар зохиогч Юндэндоржийг дурдсангүй ганцхан шанзодба Дамчойравжаа хэвд сийлүүлэв хэмээсэн байх бөгөөд мөн тэр оны эцсээр дахин бар сийлүүлж, Юндэндорж ванг зохиогч

хэмээн нэмж оруулсан³ боловч өмнөх бараас илүү урт төгсгөлийн үгтэй болсноос тэр үү, дэлгэрлийг олж чадсангүй [Отгонбаатар, Цендина 2014, 23-24] энэхүү цагаан толгой нь зохиогчийнхоо нэрээр бус харин бард сийлүүлсэн өглөгийн эзнийхээ нэрээр алдаршсан ажээ.



Сурвалжийн агуулга, шинж чанар

Нэгэнт дурдсанчлан, тус сурвалж манж, хятад хоёр хэлээрх бичвэрээс бүтнэ. Үүнд, манж бичвэрт, түшмэлийн тоо, Хадгалсан данс хар, Сайд нарын хууль болгон мөрдөх хэрэг зүйл, тухайлбал сайдын харьяат Түшээт хан, Сэцэн хан хоёр чуулганы хошууны тоо, ноёдын хэргэм, хоёр аймгийн хариуцах өртөө, харуулын тоо, түүнийг захирах тайж түшмэд, санд хадгалсан мөнгө, түүнийг хэрхэн албанд хэрэглэх, түшмэдийн цалингийн хэмжээ, хэрхэн хаанаас авахуулах, сайд түшмэдийн уналга морь, Дээр айлтгах тогтмол хэргийг айлтгах, барих ангийн махыг явуулах тухай нэг бүрчлэн дурджээ. Түүний дараа

³ *ingri-yin tedkügsen-ü tabin dörbedüger on šarayčın takiy-a jil-ün ebül-ün ekin sarayin buyan öljei büriddügsen šar-a luu edür erdeni sečen dalai šangjodba damčoyirabjai. degedü vacır dar-a blam-a-yin šabdan batudču qamuy amitan qotalay ar amur boltuyai kemen čaylasi ügei buyan sedkil egüskejü mongyol-un jayun üsüg ba erkim itegel. nom-i bičigülü-y-e kemegsen-i jarliy-iyar jaruysan küriyen-dür sayuju kereg sidkegči sidar-tur yabuqu qalq-a-yin jegün yar-un čerig-i jakiraqu tusalayči jangjun jasad-un törü-yin giyün vang. törü-yin epü yündündorji bi ber čing ünenkü süjüg-i sanaju. šajin-u nara boluysan degedü vacır dara jibzundamba blam-a-yin ölmei lingqu-a ulam tungyalay batudču burqan-u šajin arban жүг-tür delgereged. qotala qamuy amitan čaylasi ügei amuyulang jiryalang-i edlejü qočurli ügei darui türgen-e degedü qutuy-yi olqu boltuyai kemen mongyol-un jayun üsüg ba. megdzem nom-i bičijü. erdeni sečen dalai sangjodba damčoyirabjai seyilgeged süngbüm-yin-dür talbibai.:* [Отгонбаатар, Цендина 2014, 28]

сурвалжийн гуравны нэг орчим хувийг эзлэх нь Оростой харилцсан хэрэг буюу Орос зүгийн харуулыг хэзээ хэрхэн байгуулсан, улмаар харуулын газар гарсан томоохон хэрэг болох 1767 оны Улханы харуулын хэрэг, 1783 оны Улаалзайн хэргийн учир явдал, улмаар Хиагтын худалдааг удаа дараа хаасан, Эрхүү хотын губернаторын тухай мэдээлэл, 1727 онд Оростой тогтоосон Хиагтын гэрээний 11 зүйл, 1792 онд нэмсэн зүйл, мөн онд Хүрээний сайд нар Хиагтад одож Эрхүүгийн губернаторт сурган ухуулсан 5 зүйл хийгээд дээрх Хиагтын гэрээний 11 зүйлийн 10-р зүйлийг хасч тогтоосон тухай байна. Үргэлжлүүлэн, 1768 онд үр хүүхэдгүй бол хэрхэн хүний хүү тэжээх, өв хөрөнгийг хэрхэн өвлүүлэх тухай хоёр заалт, 1783 онд хоёр аймаг, шавь гурван газраас нийгэмчлэн ээлжлэн жасаа гаргах мөнгө, яамны ажилтаны цалин хүнс, Хүрээний өмнө этгээдийн 14, Хиагт хүртэл тавьсан халхын 11 өртөө, Орос зүг тавьсан 46 харуулын нэр, харуулын цэрэг, зангийн тоо, 1759 болон 1786 онд харуулын дотуур сэрэмжлэн цэрэг цагдаа суулгасан, 1772 онд Орост оргосон 32 хүнийг эгүүлэн авсан, 1771 онд торгууд нар Оросоос ирсэнийг товч дурджээ. Түүний дараа, Орос, Прусс, Франц зэрэг өрнөдийн оронд холбогдох товч мэдээлэл дурдсаны эцэст, зохиогч өөрийн хошууны эр төөлсөн дансыг хавсаргажээ. Үүнтэй харьцуулахад, хятад бичвэр нь хэмжээ, агуулгын хувьд төсөр хураангуй бөгөөд яамны түшмэлийн орон тоо, Хадгалсан ном зүйл, уулын тахилга болон сайдын газар хэрэглэх унаа морь, Тогтмол айлтгах хэрэг, хоёр аймгийн хошууны тоо, ноёдын хэргэм, Тогтсон хугацаанд шалгах байцаах хэргийг зүйл дараалан дурдсан нь агуулгын хувьд манж бичвэртэй давхцаж байна. Өөрөөр хэлбэл, хятад бичвэрт Оростой харилцсан хэрэг явдал, харуул, өртөөний тухай огт дурдаагүйн дээр эр төөлсөн данс мөн байхгүй байна.

Эндээс үзвэл, тус сурвалжийн гол агуулга нь Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын эрхлэн шийтгэх үүрэгт ажил болох Хиагтын хоёр газар, Хан уул, Хэрлэн барс хотын хоёр чуулган, Жавзандамба хутагтын шавь нар, Халхын дөрвөн аймгийн гэр харуул, Хүрээний өмнө хойно байх хоёр замын өртөө хийгээд Оростой хэлэлцэж тогтоосон хэргийг нэг бүрчлэн тоочин жагсаасан байна. Харин Юндэндоржийн хошууны эр төөлсөн данс нь сурвалжийн агуулгад шууд холбоогүй, зохиогч ташрамд хавсаргасан бололтой. Тиймээс тус сурвалжийн агуулга нь Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын ажил үүрэг, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах, мэдвэл зохих хэрэг зүйл байна.

Үүнд, тус сурвалжийн хятад нэр, ерөнхий бүтэц нь “Ховдын хэргийн зүй”, “Илийн хэргийн зүй”, “Өрөмчийн хэргийн зүй”, “Тарвагатайн

